



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР

Булган
Пүрэвжав НОМИНЧИМЭГ
Рэнцэн
Баттулга МАРГАД-ЭРДЭНЭ
Зээрднүүд
Борчулуун БОЛОРЦЭЦЭГ
Гөрөөчин
Аюурзана ГАНЗОРИГ

**АЖЛЫН БАЙРАНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ
ХОЛБОСОН ПЛАТФОРМЫН ШААРДЛАГА
ТОДОРХОЙЛОХ**



Мэргэжлийн индекс

EO4120101

Бизнесийн удирдлагын

Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдсан:

Б.Мөнхбаяр /MBA/
Б.Мөнхзаяа /Ph.D/
Г.Намужин /MBA/
Н.Саранчимэг /MBA/

Улаанбаатар. 2023



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МАСТЕРЫН ХӨТӨЛБӨР



Булган
Пүрэвжав НОМИНЧИМЭГ
Рэнцэн
Баттулга МАРГАД-ЭРДЭНЭ
Зээрднүүд
Борчулуун БОЛОРЦЭЦЭГ
Гөрөөчин
Аюурзана ГАНЗОРИГ

**АЖЛЫН БАЙРАНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ
ХОЛБОСОН ПЛАТФОРМЫН ШААРДЛАГА
ТОДОРХОЙЛОХ**



Мэргэжлийн индекс

E04120101

Бизнесийн удирдлагын

Мастерын зэрэг горилсон судалгааны ажил

Удирдагч: Б.Мөнхбаяр /MBA/

.....Б.Мөнхзаяа /Ph.D/

..... Г.Намужин /MBA/

..... Н.Саранчимэг /MBA/

Улаанбаатар. 2023

ГАРЧГИЙН ТОВЬЁОГ

МЭДЭГДЭХ ХУУДАС.....	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ.....	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	vii
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	viii
УДИРТГАЛ	1
Судалгааны зорилго, зорилтууд.....	2
Судалгааны хамрах хүрээ.....	2
Практик ач холбогдол.....	2
Судалгааны онол, арга зүй.....	2
Судалгааны хүлээгдэж буй үр дүн.....	2
Дипломын бүтэц, хэмжээ.....	2
I БҮЛЭГ. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА, ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН СУДАЛГАА	4
1.1 Судлагдсан байдлын судалгаа.....	4
1.2 Ажлын байранд суурилсан сургалтын онцлог, зохион байгуулалт.....	4
1.3 Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн олон улсын туршлага.....	7
II БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	13
III БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ.....	15
2.1 Монгол улсын дээд боловсролын салбарт АБССХ хэрэгжиж буй өнөөгийн байдал.....	15
2.2 СЭЗИС-д АБССХ хэрэгжиж буй өнөөгийн байдал.....	17
2.3 СЭЗИС-ийн карьерийн үйлчилгээг хэрэгжүүлж буй өнөөгийн байдал.....	24
IV БҮЛЭГ. СЭЗИС-ийн АБССХ-ийн нэгдсэн платформын шаардлага тодорхойлох нь	26
4.1 СЭЗИС-д АБССХ-ийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал.....	26
4.2 Олон улсын карьерийн үйлчилгээг хэрэгжүүлж буй тэргүүн туршлага.....	40
4.3 СЭЗИС-д Карьер үйлчилгээ болон АБССХ-ийг сайжруулах арга зам.....	46
4.4 Карьер үйлчилгээний платформын шаардлага.....	48
ДҮГНЭЛТ.....	59
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	60
НОМ ЗҮЙ	i
ХАВСРАЛТ.....	iv

МЭДЭГДЭХ ХУУДАС

Энэхүү төсөлт ажил нь төслийн багийн бүтээл болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч бөгөөд тус сургуулийн номын санд судалгааны ажлыг нийтийн хүртээл болохыг зөвшөөрч байна.

Магистрантын нэр:

П.Номинчимэг
Б.Маргад-Эрдэнэ
Б.Болорцэцэг
А.Ганзориг

Гарын үсэг:

Огноо:

ТАЛАРХАЛ

Энэхүү төсөлт ажлыг амжилттайгаар гүйцэтгэхэд гүн тусалцаа үзүүлсэн удирдагч багш Ректор МВА Б.Мөнхбаяр, Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор Ph.D Б.Мөнхзаяа, Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч МВА Г.Намужин, Мэдээллийн системийн менежментийн тэнхимийн эрхлэгч МВА Н.Саранчимэг, Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш МВА Э.Жаргалмаа нартаа талархсанаа илэрхийлж ажлын өндөр амжилт хүсье!

ТОВЧ ХУРААНГУЙ

Монгол Улсад Европын олон улсад амжилттай туршигдсан АБССХ-ийг СЭЗИС нь Голомт болон Төрийн банктай хамтран боловсруулж, нутагшуулан цаашид үндэсний стратеги болгон хөгжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар СЭЗИС нь банк, санхүү, аялал жуулчлалын хөтөлбөрүүдээр АБССХөтөлбөрийг 2022 оны хичээлийн жилээс туршин хэрэгжүүлсэн ба Банк, Санхүү хөтөлбөрийн нийт 20 оюутан хамрагдсан байгаагаас эхний ээлжийн 10 оюутан АБССХөтөлбөрт 6 сар хамрагдаж амжилттай дууссан ба хоёрдугаар ээлжийн 10 оюутан ажлын байран дээр ажиллаад 2023 оны 05 дугаар сарын байдлаар 3 сар өнгөрсөн байна.

Юун түрүүнд АБСС-ийн тухай болон АБССХ-ийн онцлог зохион байгуулалтыг судалж, олон улсын туршлагын харьцуулсан судалгаа хийж, СЭЗИС-ийн өнөөгийн хэрэгжүүлж буй АБССХ-ийг сайжруулан үр дүнтэй арга замыг тодорхойлох нь чухал байв.

Мөн оролцогч талуудаас судалгаа авч тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон платформын шаардлагыг оролцогч тал бүрээр дэлгэрэнгүй гаргаж, уг шаардлагад тулгуурлан платформын прототайпыг гаргасан. Олон улсын их дээд сургуулиудын тэргүүн туршлагаас харахад тус хөтөлбөрийг “Career” үйлчилгээгээр дэмжиж ирсэн байна. Их дээд сургуулиудын карьер үйлчилгээгээр тэргүүлэгч Массачусетсын Технологийн Институт, Сиднейн Их сургууль, Цингхуа Их сургууль, Оксфордын Их сургууль, Токиогийн Их сургуулиудын карьер сайтуудын харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр АБССХ-ийн оролцогч талуудыг холбосон платформын ерөнхий цэсүүдийг гаргасан.

Эдгээр туршлага нь СЭЗИС-ийн оролцогч талуудыг холбосон платформ хөгжүүлэх бодит үндэслэл болж байна. Уг судалгааны ажлын үр дүнд СЭЗИС, Аж ахуй нэгж байгууллагууд, оюутнууд хоорондын уялдаа холбоог сайжруулах, мэдээ мэдээллийг хүртээмжтэй байлгахад чиглэсэн, цаашлаад төгсөгчдийг хамруулсан оюутан, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн платформ болгон хөгжүүлэх дээр санал гарган прототайпыг гаргасан болно.

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

<i>Хүснэгт 1. Дадлага болон АБССХ-ийн ялгаа</i>	6
<i>Хүснэгт 2. БНХАУ-ын АБССХ-ийн хэрэгжүүлэн үе шатууд</i>	10
<i>Хүснэгт 3. Азийн бүс нутгийн улсуудын бодлого зохицуулалт</i>	12
<i>Хүснэгт 4. Хөтөлбөрт хамрагдаж буй оюутны тоо (байгууллагаар)</i>	21
<i>Хүснэгт 5. Хөтөлбөрт хамрагдаж буй оюутны дадлагажиж буй албан тушаал</i>	22
<i>Хүснэгт 6. Аялал жуулчлалын тэнхимийн АБССХ-ийн хичээлүүд</i>	23
<i>Хүснэгт 7. СЭЗИС-ийн вебсайт дээрх карьер үйлчилгээний хэсэг</i>	24
<i>Хүснэгт 8. СЭЗИС-ийн карьер үйлчилгээнд хийсэн SWOT шинжилгээ</i>	25
<i>Хүснэгт 9. Оролцогч талуудад тулгарч буй асуудлууд</i>	26
<i>Хүснэгт 10. Ажиллахыг хүссэн албан тушаал</i>	27
<i>Хүснэгт 11. Хөтөлбөрийн талаарх нээлттэй асуулга.</i>	33
<i>Хүснэгт 12. Удирдагч багш нараас авсан нээлттэй асуулгын хариулт</i>	37
<i>Хүснэгт 13. Зохицуулагчаас авсан асуулга, хариулт</i>	38
<i>Хүснэгт 14. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшингээр олон улсын их сургуулиудын эрэмбэ</i>	40
<i>Хүснэгт 15. Массачусетсын Технологийн Институтын карьер үйлчилгээний сайтын мэдээлэл</i>	40
<i>Хүснэгт 16. Сиднейн Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл</i>	41
<i>Хүснэгт 17. Оксфордын Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл</i>	42
<i>Хүснэгт 18. Цингхуа Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл</i>	43
<i>Хүснэгт 19. Токиогийн Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл</i>	44
<i>Хүснэгт 20. Харьцуулсан матриц</i>	45
<i>Хүснэгт 21. ОУ-н их сургуулиудын карьер үйлчилгээний сайтын бүтэц ба СЭЗИС өнөөгийн байдал</i>	47
<i>Хүснэгт 22. Карьер үйлчилгээний хөгжүүлэх санал</i>	48
<i>Хүснэгт 23. Платформын шаардлага (Оюутан)</i>	49
<i>Хүснэгт 24. Платформын шаардлага (Ажил олгогч)</i>	52
<i>Хүснэгт 25. Платформын шаардлага (Сургууль)</i>	54

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дагалдан суралцах хэлбэр	5
Зураг 2. Судалгааны дизайн	13
Зураг 3. Оюутны хөгжлийн бодлогын чиглэл.....	18
Зураг 4. АБСС-н оролцогч талуудын харилцааны схем.....	19
Зураг 5. АБССХ-ийн оролцогч талуудын одоогийн процессын зураглал	20
Зураг 6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байранд бэлтгэх чиглэлийн хүрээнд хийгдэх ажлууд	24
Зураг 7. Оюутнуудын дадлажигч буй байгууллага	27
Зураг 8. Өөрийн хүссэн албан тушаалдаа ажиллаж чадсан эсэх	27
Зураг 9. Ажлын байран дээрээс эзэмшсэн ур чадварууд.....	28
Зураг 10. Ажлын байран дээрээс эзэмшсэн зөөлөн ур чадварууд	28
Зураг 11. Дараах зүйлсийг үнэлнэ үү. /1-Маши муу, 2-Муу, 3-Дундаж, 4-Сайн, 5-Маши сайн/	29
Зураг 12. Хөтөлбөрөөс ойлгомжгүй, тодорхойгүй зүйлс байсан уу?.....	29
Зураг 13. Тайлан хамгаалалтын үнэлгээ, ил тод ойлгомжтой байсан уу?	30
Зураг 14. . Ментор нь мэдээллээр хэр хангаж байсан бэ?	30
Зураг 15. Хөтөлбөрийн оролцогч талуудтай харилцаа холбооны ямар сувгаар харилцаж байсан бэ?	30
Зураг 16. Оролцогч талуудыг холбосон нэгдсэн платформ байх шаардлагатай юу?.....	31
Зураг 17. Хөтөлбөрийн талаарх мэдээллийг анх хаанаас авсан бэ?	31
Зураг 18. Тус хөтөлбөрийг сонгосон шалтгаан?	31
Зураг 19. АБССХ-ийн дадлагажих 6 сарын хугацаа хэр тохиромжтой байсан бэ?	31
Зураг 20. Ажилласан байгууллагын юу нь таалагдсан бэ?	32
Зураг 21. Ажилласан байгууллагын юу нь таалагдаагүй вэ?	32
Зураг 22. Цалингийн хэмжээ.....	33
Зураг 23. Тохиромжтой хэмжээ.....	33
Зураг 24. Удирдагч багш болохоос өмнө хөтөлбөрийн талаар хэр мэдээлэлтэй байсан бэ?	34
Зураг 25. Одоо сургуулийн зүгээс хөтөлбөртэй холбоотой мэдээ мэдээллээр хэр хангаж байна вэ?	34
Зураг 26. Дадлагын ментортой харилцахдаа ашиглаж буй харилцаа холбооны суваг	35
Зураг 27. Дадлагажигч оюутантай харилцаа холбооны ямар сувгаар холбогдож байна вэ?	35
Зураг 28. Хөтөлбөр эхэлснээс хойш оролцогч талуудтай хэдэн удаа холбогдсон бэ?	36
Зураг 29. Хөтөлбөрт удирдагч багшаар ажилласнаар таны ачаалал хэр нэмэгдсэн бэ? ..	36
Зураг 30. Хөтөлбөр хэрэгжиж байгаа хугацааг тохиромжтой гэж үзэж байна уу?	36
Зураг 31. Танилцах болон мэргэжлийн дадлагатай харьцуулахад АБССХ-ийн оюутанд бий болгож буй давуу талыг үнэлнэ үү. /5 Их, 4 Дунд, 3 Бага/	37
Зураг 32. АБСС Платформын шаардлага	48
Зураг 33. АБСС-ын процесс зураглал (To Be)	58
Зураг 34. Оролцогч талд төгсөгчийг оруулсан платформын шаардлага (Санал, зөвлөмж)	61

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

<i>Хавсралт 1. Дадлагажигч оюутнуудаас авсан судалгааны асуулгын маягт</i>	<i>iv</i>
<i>Хавсралт 2. Удирдагч багшаас авсан судалгааны асуулгын маягт</i>	<i>vii</i>
<i>Хавсралт 3. Сургуулийн зохицуулагчаас авсан судалгааны асуулга.</i>	<i>ix</i>
<i>Хавсралт 4. Ажлын байрны төрөл тус бүрээр мэдээлэл харагдах байдал</i>	<i>x</i>
<i>Хавсралт 5. Ажлын байрны зар ажлын байрны төрлүүдээр харах</i>	<i>xi</i>
<i>Хавсралт 6. Тайлангийн үзүүлэлтүүд</i>	<i>xiii</i>
<i>Хавсралт 7. Ажил олгогчийн эрх, үүрэг</i>	<i>xiv</i>
<i>Хавсралт 8. Бүтэн цагийн ажилд зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулга</i>	<i>xv</i>
<i>Хавсралт 9. Дадлагад зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулгын загвар</i>	<i>xv</i>
<i>Хавсралт 10. Хагас цагийн ажилд зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулгын загвар.....</i>	<i>xvi</i>
<i>Хавсралт 11. Сайн дурын ажилд зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны загвар</i>	<i>xvi</i>
<i>Хавсралт 12. АБССХ-т зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулгын загвар</i>	<i>xvii</i>
<i>Хавсралт 13. АБССХ-т оролцсон байгууллагаас авах судалгааны асуулгын загвар</i>	<i>xviii</i>
<i>Хавсралт 14. СЭЗИС-ийн оюутнуудад ажил олгогч байгууллагаас авах судалгааны асуулга</i>	<i>xviii</i>
<i>Хавсралт 15. Платформын прототайп.....</i>	<i>xviii</i>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Товчилсон үгийн тайлбар
АБССХ	Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр
ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага
СЭЗИС	Санхүү эдийн засгийн их сургууль
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
МУ	Монгол улс
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
СУИС	Соёл урлагийн их сургууль
ОУ	Олон улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ЗГ	Засгийн газар
ААН	Аж ахуй нэгж
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс
ИДС	Их дээд сургууль
ИС	Их сургууль

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

ERASMUS - Европын холбооны орнууд болон Австрали улсад хэрэгждэг их, дээд сургууль төгсөгчдийн ажлын байрыг дэмжих зорилготой Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийн нэршил

IUT – Францын Льюмер Лионы их сургуулийн Технологийн Институт

ТҮЛХҮҮР ҮГ

АБСС, АББСХ, Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр, Платформын шаардлага тодорхойлох, Прототайп, Карьер үйлчилгээ

УДИРТГАЛ

2022 онд БШУЯаман дээр болсон хэлэлцүүлэг дээр “Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах” төсөлт ажлын хүрээнд Банк санхүүгийн төлөөлөл болох 12 ажилтан, СЭЗИС-ийн Бакалаврын хөтөлбөрийн нийт 184 оюутан болон Голомт банкны GStudent club-н чиглэл бүрийн төгсөх курсийн 23 оюутнуудыг хамруулсан байна. Тус судалгааны үр дүнгээс харахад оюутны өөрийн ур чадварын үнэлэмж болон байгууллагын үнэлэмж хооронд маш том зөрүү байсан нь харагдсан ба нийт 10 ур чадварыг 1-5 оноогоор үнэлүүлэхэд оюутны үнэлгээ 4.2, банкны үнэлгээ 2.9, ур чадварын зөрүү нь 1.3 байсан байна. Мөн тус судалгаагаар АБССХөтөлбөрийг ажил олгогч талаас хэрэгжүүлэхдээ дадлагажигч оюутныг цалинтай дадлагажуулах боломжтой, оюутнууд АБССХ-т хамрагдах өндөр сонирхолтой байгааг шинжилж гаргасан байна.

АБСС-ын хөтөлбөрийг Австрали, Европт хүлээн зөвшөөрч, насан туршийн боловсролын хэлбэрээр хэрэгжүүлж улмаар Европын алсын хараат зорилгын нэгэн хэсэг болжээ. Европын улсуудад АБСС-ын үндсэн хэлбэртэй (дагалдан сургалт/хос боловсрол/дадлага) холбоотой шинэ бодлого, хэрэгжилтийн тогтолцоо бий болсон. (Хүрэлбаатарын ХЭРЛЭН бусад, 2022)

2020 онд ERASMUS+ дээд боловсролын чадавх бэхжүүлэх (Capacity Building in Higher Education - CBHE) төсөлд нийт 1032 төслийг мэдүүлснээс 164 төсөл сонгогдсоны дотор Отгонтэнгэр их сургуулийн MONGWBL төсөл шалгарсан нь МУ-ын их дээд сургуулиудаас анх удаа шалгарсан 100 хувийн санхүүжилттэй төсөн байсан. Erasmus+ нь Европ дахь боловсрол, сургалт, залуучууд спортыг дэмжих Европын холбооны хөтөлбөр юм. Уг төсөл нь 3 жилийн хугацаанд хэрэгжих ба ерөнхий зохицуулагчаар Отгонтэнгэр их сургууль ажиллаж байна. Төслийн үр дүнд ажилд суурилсан сургалтыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхтэй холбоотой бодлогын баримт бичгийг боловсруулж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, тус сургалтыг хэрэгжүүлэх загвар хөтөлбөрийг төслийн оролцогч байгууллагууд хамтран боловсруулах бөгөөд дээд боловсролын байгууллага, ажил олгогчдын нягт уялдаа хамтын ажиллагааг уламж сайжруулах замаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх юм. Европын 5 орны их сургуулиуд (Льюмер Лион их сургууль, Берлиний эдийн засаг, хуулийн сургууль, Брасовийн Трансильванийн их сургууль, Македоны их сургууль) МУ-ын 5 их сургууль (Отгонтэнгэр сургууль, СЭЗИС, ХААИС, Дорнод их сургууль, СУИС), 4 байгууллага (БШУЯам, Төрийн банк, Голомт банк, Монголын аялал жуулчлалын холбоо) хамтран хэрэгжүүлж байна. (Голомтбанк, 2022)

СЭЗИС нь банк, санхүү, аялал жуулчлалын хөтөлбөрүүдээр АБССХөтөлбөрийг 2022 оны хичээлийн жилээс туршин хэрэгжүүлсэн ба Банк, Санхүү хөтөлбөрийн нийт 20 оюутан хамрагдсан байгаагаас эхний ээлжийн 10 оюутан АБССХөтөлбөрт 6 сар хамрагдаж амжилттай дууссан ба хоёрдугаар ээлжийн 10 оюутан ажлын байран дээр ажиллаад 3 сар өнгөрсөн байна. (СЭЗИС, Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрт 6 сар хамрагдаж, эхний ээлжийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж дууслаа, 2023)

Цаашид оюутны тоо болон ажил олгогч байгууллагын тоо улам нэмэгдэхийн хэрээр оролцогч талууд нягт уялдаа холбоотой ажиллаж байж хөтөлбөр урт хугацаандаа

амжилттай хэрэгжинэ. Ийм техник технологи хөгжсөн өнөө үед олон улсад туршин хэрэгжигдсэн тус хөтөлбөрийн оролцогч талуудыг холбосон платформын тэргүүн туршлагуудыг судалж хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж харж байна.

Судалгааны зорилго, зорилтууд

Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй арга замыг тодорхойлох, оролцогч талуудыг холбосон платформын шаардлага тодорхойлох.

Төсөлт ажлын зорилго дээр үндэслэн дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. АБССХөтөлбөрийн судлагдсан байдлын судалгаа болон ОУ-ын туршлагыг судлах
2. АБСС болон карьер хөгжилтэй холбоотой өнөөгийн байдлын судалгаа хийх
3. Цаашид хэрэгжүүлэх санал зөвлөмж боловсруулах
4. Платформын шаардлага тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах

Судалгааны хамрах хүрээ

- ✓ Бакалавр 2.0 хөтөлбөр
- ✓ АБССХөтөлбөрийн оролцогч талууд

Практик ач холбогдол

АБССХ-ийн агуулгыг сайжруулж, хөтөлбөрийн оролцогч талуудын үр дүнтэй хамтын ажиллагааг нэмэгдүүлж, оюутны карьер хөгжлийг дэмжих. Оюутны хөдөлмөр эрхлэлтийн талаарх өгөгдөл цуглуулах, өгөгдөлд шинжилгээ хийх, тайлан боловсруулах.

Судалгааны онол, арга зүй

АБССХ холбоотой олон улсын туршлагыг судлан харьцуулалт хийх, хөтөлбөрийн оролцогч талуудтай фокус бүлгийн ярилцлага болон анкетын аргаар судалгаа хийж үр дүнг нэгтгэх, ижил төстэй системийн харьцуулсан судалгаа хийх, платформын шаардлага тодорхойлох.

Судалгааны хүлээгдэж буй үр дүн

Судалгааны ажлаар АБССХ-ийн АБССХ-ийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, сайжруулах санал зөвлөмж боловсруулах, олон улсын их дээд сургуулиудын карьер үйлчилгээний сайтыг судалж, сургуулийн карьер үйлчилгээний өнөөгийн байдалтай харьцуулан, санал зөвлөмж боловсруулах, хөтөлбөрийн оролцогч талуудыг холбосон платформын шаардлага тодорхойлох, прототайп боловсруулах.

Дипломын бүтэц, хэмжээ

Уг судалгааны ажил нь удиртгал, үндсэн дөрвөн бүлэг, 10 дэд бүлэг болон дүгнэлт, санал зөвлөмж, ном зүй, хавсралтаас бүрдэнэ.

I. БҮЛЭГ СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА, ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН СУДАЛГАА

1.1 Судлагдсан байдлын судалгаа

СЭЗИС нь АБССХ-ийг Банк санхүү, даатгалын мэргэжлээр Голомт банк болон Төрийн банктай хамтран боловсруулж, нутагшуулан, цаашид үндэсний стратеги болгон хөгжүүлэхээр зорилт тавьсны дагуу их дээд сургууль төгсөгчдийг онол, практик хосолсон, ажлын байранд цалинтай мэргэших боломжийг бүрдүүлсэн, шаардлагатай мэдлэг ур, чадварыг олгоход чиглэсэн хөтөлбөрийг боловсруулах судалгааны ажлуудыг хийсэн байна.

Мөн АБССХ хэрэгжилтийн олон улсын туршлагыг судлан, европын талаас хамтран оролцогчид болох Герман дахь Берлиний эдийн засаг, хуулийн сургууль, Францын Лионы их сургууль, Румын улсын Трансилваниагийн их сургууль, Грекийн Македонийн их сургуулийн хамтран боловсруулсан АБССХ-ийг олон улсад хэрэгжүүлэх гарын авлага зэрэгт үндэслэн хөтөлбөрийн үндсэн өгөгдлийг боловсруулсан.


1.2 Ажлын байранд суурилсан сургалтын онцлог, зохион байгуулалт

“Дагалдан сурах буюу дадлага”-ын талаар олон судалгааны ажил хийж, боловсруулсан Европын Мэргэжлийн Сургалтын Хөгжлийн Төв (CEDEFOP)-ийн ашиглахаар сонгосон нэр томъёо нь “Apprenticeship” юм. Энэ нэр томъёог Европын холбооноос илүүд үздэг боловч дэлхий нийтээрээ ашиглаж хэвшээгүй ба internship, trainee-ship зэрэг үг хэллэгүүдийг мөн ашигладаг., trainee-ship нэр томъёонуудыг эрүүл мэндийн салбарт илүү ашигладаг байна. (INDEED, 2023)

Apprenticeship гэдэг нь мэргэжил, ур чадварыг ажлын байран дээрээс тодорхой хугацаанд олж аван, үргэлжлүүлэн тухайн ажлын байран дээрээ ажиллахад нь шаардлагатай чадварыг эзэмшихэд нь тусалдаг. Дагалдан суралцах хугацаа нь салбар, мэргэжил, үүрэг, соёлоос хамааран ялгаатай байдаг.

Apprenticeship нь бие даасан, хамтарсан гэсэн үндсэн 2 төрөлтэй. Бие даасан нь ямар нэгэн боловсролын байгууллагын оролцоогүйгээр ажил олгогчид өөрсдөө зохион байгуулж удирддаг. Хамтарсан төрөл нь боловсролын байгууллага болон ажил олгогчдын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж, удирдан явуулдаг. Эдгээр нь засаглалын хувьд харилцан адилгүй ба зарим нь ажил олгогчийн зүгээс илүү, зарим нь боловсролын байгууллага нь илүү байдаг боловч сургалтын хөтөлбөртэй салшгүй холбоотой байдаг. Онолыг практикт хэрэгжүүлэх, мэдлэгийг чадваржуулах нь үндсэн зорилго нь юм. (OECD, 2023)

Зураг 1. Дагалдан суралцах хэлбэр



Эх сурвалж: (ERASMUS+Programme of the Europran Union, 2023)

АБСС-н ойлголтыг тойрсон хэлэлцүүлэгт ажлын байран дээр суралцах, дагалдан сургалтаар дамжуулж суралцах гэх ойлголт багтаж байгаа бөгөөд эдгээр нэр томъёоны дагуу АБСС гэж бараа, үйлчилгээний үйлдвэрлэлд бодит ажил гүйцэтгэж, түүний үр дүнд суралцах гэсэн утга илэрхийлнэ. Олон улсын туршлагаас харахад АБСС нь дор дурдсан нийтлэг давуу талыг агуулдаг хэдий ч зөвхөн доорх ойлголтоор хязгаарлаж болохгүй. Үүнд:

- Суралцагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ;
- ААНБ-ын эрэлтэд тохирох ур чадварыг олгоно;
- ДБСБ-ААНБ-ын үр дүнтэй түншлэлийг хөгжүүлнэ;
- Илүү хүртээмжтэй, чанартай ДБ-ын тогтолцоог бий болгоно.

Харин АБСС нь ААНБ-ын болон үндэсний түвшинд доорх үр ашгийг үзүүлдэг. Үүнд:

Байгууллагын түвшинд АБСС нь сурган хүмүүжүүлэх шинэ арга барилыг хэрэгжүүлэх, багш, захиргааны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, бэхжүүлэх, боловсролын чанарыг сайжруулах, оюутны мэдлэг, туршлагад суурилсан сургалтыг бусад ААНБ-тай хамтран зохион байгуулахын тулд үр дүнтэй харилцаа холбоо тогтоох замаар төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. Хамгийн чухал нь тухайн байгууллагын өөрийн үнэ цэн, түүнийг дагаж ирж буй үр дүн, өөрчлөлт байдаг. Түүнчлэн байгууллагын оюуны болон бүтцийн капитал, чадварын талаарх мэдлэгийг бий болгодог.

АБСС-аар ажлын байранд дагалдан суралцагчдын өргөн хүрээтэй хөгжлийг дэмждэг бөгөөд тэдний гүйцэтгэж буй үүргээр дамжуулж хөрөнгө оруулалт бий болж, мэргэжлийн ур чадвар, урам зориг нэмэх нөлөө үзүүлдэг байна.

ААНБ-ын бүтэц, ажлын арга барилд өөрчлөлт оруулах, бизнесийн шинэ чиглэлийг тодорхойлох, гадаадад хүлээн зөвшөөрөгдөх, нэр хүндийг бий болгох зэргээр ихээхэн өргөн хүрээнд эергээр нөлөөлөх боломжтой.

Үндэсний хэмжээнд АБСС нь ДБСБ, ААНБ хоорондын харилцан үр ашигтай түншлэлийг бэхжүүлж, ур чадварын уялдаа холбоог хангаж, төгсөгчдийн ур чадварын түвшнийг дээшлүүлнэ.

Оюутны практик ур чадварыг хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлтэй холбох уламжлалт механизм бол дадлага бөгөөд боловсролын үйл явцын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Оюутан танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлж, ажиглалт, судалгаа, боловсруулалт хийх чадвар, дадал эзэмших, өөрийн мэргэжлийн салбарт тавигдаж буй зорилт, тулгамдсан асуудлын талаар тодорхой мэдээлэл олж авах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг ажлын байран дээр эзэмших зорилготой суралцах үйл ажиллагааг дадлага гэнэ. Энэхүү тодорхойлолтын дагуу АБСС нь дадлага хэрэгжих цорын ганц нөхцөл мөн.

Дадлагын зорилго нь оюутан суралцах хугацаанд эзэмшсэн онолын мэдлэгийг бататгах, гүнзгийрүүлэх, мэргэжлийн ур чадварын хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино. ДБСБ-ын хувьд АБСС-ыг хөтөлбөрийн төрөл болон онцлогоос шалтгаалан дадлагыг 3-4 хэлбэрээр зохион байгуулдаг бөгөөд сургалтын журамдаа дадлагын хэлбэрийг зааж өгсөн бөгөөд эдгээр чиглэлийн дагуу дадлага зохион байгуулдаг. Тухайлбал: Үйлдвэрлэлийн дадлага, танилцах дадлага, мэргэших дадлага /интерншиш/, хээрийн дадлага, дадлагын интерактив семинар, мэргэшүүлэх дадлага.

Дадлагын нийтлэг байдлыг тодорхой хэдэн үзүүлэлтүүдээр АБССХ-тэй харьцуулан ялгааг доорх хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 1. Дадлага болон АБССХ-ийн ялгаа

	Дадлага	АБССХ
Нийт кредит цаг	АБССХ-г хамрагдаж байгаа оюутнуудын судлах нийт кредит нь бакалаврын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан кредиттэй тэнцүү байна.	АБССХ-ийн кредит болон үнэлгээг кейс сургалт, бизнесийн дадлага, мэргэжлийн дадлага, төгсөлтийн шалгалт /диплом/, бусад мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн дүнд дүйцүүлнэ.
Дадлагын кредит цаг	126 кредит цагтай, хээрийн дадлага нь 3 кредит, үйлдвэрлэлийн дадлага нь 4 кредит цагийн багтаамжтай байна.	Дадлага нь 20 кредит цаг байх бөгөөд энэ нь бакалаврын сургалтын төлөвлөгөөний нийт кредитэд багтсан байна.
Хугацаа	Хээрийн дадлага нь 2-р курсийн зуны амралтаар, үйлдвэрлэлийн дадлага нь 4-р курсийн намрын улиралд батлагдсан удирдамжийн	3 болон төгсөх курсын оюутныг нийт 6 сарын хугацаанд хамруулна.

	дагуу явагдахаар сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.	
Цалинтай эсэх	Ихэвчлэн цалингүй ААНБ-тай тохиролцож болно.	Оюутанд өөрийн байгууллагын үндсэн ажилтанд тавигдах шаардлагын дагуу үнэлж, цалин, урамшуулал тогтоож олгоно. Түүний хэмжээ, зохистой байдлыг ААНБ тодорхойлно.
Гэрээ	Үгүй	Оюутан, сургууль, ажил олгогчийн дунд гэрээ хийнэ.
Удирдамж	Дадлагын удирдамжийн дагуу оюутны зүгээс хүчин чармайлт гаргаж дадлагыг гүйцэтгэдэг.	Ажил олгогч болон сургуулийн зүгээс хариуцсан хүнтэй, дадлагын хугацаанд хөтөлбөрийн дагуу үр дүнтэй дадлагажина.
Үргэлжлүүлэн ажиллах боломжоор хангагдах	Үгүй	Тийм/Үгүй

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

1.3 Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн олон улсын туршлага

Олон улсын түвшинд АБСС-ыг дээд боловсролын системд нэвтрүүлэхдээ улс орон бүр өөр өөрсдийн нөхцөл байдал, соёлоос үүдэн төрөл бүрийн системээр нэвтрүүлж байна. Азийн бүс нутгийн улсын туршлагаас орууллаа. Манай улсын хувьд АБССХ-ыг албан ёсоор хуульчлаагүй байгаа тул ОУ-ын туршлагаудад болон өөрсдийн нөхцөл байдалд тулгуурлан шинэ боловсролын хөтөлбөр гаргах бүрэн боломжтой. Сүүлийн 3 жилийн хугацаанд дэлхий нийтээр тархсан Ковид-19 цар тахал бидэнд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг шаардаж байгаа нь эмнэлэгийн ажилчдын дутагдлаас харагдсан. Мөн эдийн засгийн хөгжлийн хурдтай эрэлт хэрэгцээтэй тулгарсан өнөөгийн нөхцөлд олон орны засгийн газар ажлын байранд сургах хөтөлбөрийг өргөжүүлэх оролдлого хийж байна. Манай улсад 2021 оноос 3 жилийн хугацаатай хэрэгжиж буй Европын холбооны санхүүжилттай “Erasmus+MONGWBL” төсөлд хамтран ажиллагч Герман дахь Берлиний эдийн засаг, хуулийн сургууль (Berlin School of Economics and Law), Францын Лионы их сургууль (University Lyon), Грекийн Македонийн их сургууль (University of Macedonia)-ийн сургуулиудын АБССХ-ийн талаарх хэрэгжүүлэлтийг олон улсын туршлага болон орууллаа.

Герман улс Berlin School of Economics and Law сургуулийн туршлага:

- ✓ 1990 ээд оноос банк санхүүгийн чиглэлээр бизнесийн удирдлагын хос хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.
- ✓ Одоогоор дээд боловсролын хос хөтөлбөрт 700 гаруй түнш аж ахуй нэгж байгууллагууд оролцож байна.

- ✓ Тус сургуульд элсэхдээ түнш ААН-тэй сургалтын гэрээ байгуулаад бакалаврын үндсэн хөтөлбөр болон АБСС нь ижил хэмжээний 6 семестэр явагддаг байна.
- ✓ АБСС-ын хугацаанд сургалтын стандарт төлөвлөгөө нь сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болох бөгөөд ААН-ийн менторын удирдамж, хяналтыг оруулсан байдаг. Оюутнуудын хичээлийн үнэлгээ нь АБСС-ын шаардлагад тэнцсэн тохиолдолд ААН-ийн хөтөлбөрт хамрагдана. Эцсийн шалгалтад оюутнууд онолын мэдлэгээ, дадлага ажлын туршлагатайгаа харьцуулж, өөрийн дүнгээ авна. Оюутны судалгааны төслүүд болон эцсийн тайлан нь онол, дадлагыг холбосон жишээ болдог. Дадлагын тайлан нь их сургуулийн багш нарын удирдлага дор бичигддэг. Ингэхдээ оюутнууд академик бичлэгийн талаар зааварчилгаа авдаг ба тэд бакалаврын дипломын ажлаа их сургууль болон ААН-тэй тохиролцсон сэдвээр бичнэ. Дээд боловсролын стандартыг хангахын тулд их сургуулийн зохицуулагч болон удирдагч багшийн хяналт, үнэлгээ чухал ач холбогдолтой.
- ✓ Тус сургууль нь АБССХ-ийн албатай байдаг байна. Хөтөлбөрийн эрхлэгч нь ажлын цагийн 50%-д багшлаад, хөтөлбөрийн түнш байгууллагуудтай холбоо тогтоох зохицуулах, танилцуулах, оюутнуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалтын төлөвлөгөө, сургалтын стандарт хөтөлбөрийг боловсронгой болгох тал дээр илүү ажилладаг байна.

Францын University Lyon их сургуулийн туршлага:

- ✓ Франц улсад “alternance” буюу “ээлжлэн солигдох” систем гэж нэрлэгддэг тусгай ажлын гэрээтэй байдаг нь маш онцлогтой.
- ✓ Тус сургууль технологийн чиглэлийн сургууль ба АБССХ-ийн загварыг 30 жилийн өмнө технологийн институтийг үүсгэн байгуулсан багш нар хөдөлмөр эрхлэлтийг хөнгөвчлөх зорилгын хүрээнд хэрэгжүүлж эхэлсэн байна.
- ✓ Хос хөтөлбөрийн системтэй ба оюутнууд нэг аж ахуй нэгжтэй 2 жилийн гэрээ хийх эсвэл хоёр өөр аж ахуй нэгжтэй нэг нэг жилийн хугацаатай гэрээ байгуулах сонголттой нь давуу талыг харуулж байна.
- ✓ Оюутнууд ажлын байранд суралцах сүүлийн 2 жилийн хугацаанд Франц дахь технологийн институтэд 2 долоо хоног ажиллаад, 2 долоо хоног их сургууль гэх байдлаар ээлжилдэг байна. Бизнесийн удирдлагын салбарын хувьд өөр хуваарийг дагаж мөрддөг: 3 өдөр /2 өдөр харин банкны салбарын оюутнуудыг их сургуулиас хамаагүй хол оршдог компаниудад ажиллах боломжийг олгохын тулд нэг сар/ нэг сар гэсэн хуваарийг баримталдаг.
- ✓ Мөн тус сургуулийн оюутнууд эхний жилдээ дадлага хийх компани сонгодог ба энэ нь сургалтын хугацаанд тооцогдоод зогсохгүй мөн дараа жилээс нь тэдний ажилд орох туршилтын хугацаанд тооцогддог байна. 2-3 өдөр үргэлжилдэг хөдөлмөрийн яармагт оролцож “Ажлын өмнөх ажлын байр”-ыг олж авах боломжтой. Энэ нь аж ахуй нэгжүүдийг их сургуульд урьж ирүүлээд, жагсаалтад орсон оюутнуудтай уулзуулан, эхлээд дадлага хийлгэж, дараа нь суралцангаа ажиллах, хэдэн жилийн дараа мэргэжлээр нь ажилд авах асуудлыг шийддэг давуу талтай.
- ✓ Оюутнуудын дадлага хийж буй аж ахуй нэгжид удирдагч багш, зохицуулагч багш нь ментор болон оюутнуудтай 4-5 удаа очиж уулзан заавар зөвлөгөө өгдөг байна.

- ✓ Оюутнууд жилийн тайлгангаа сургалтын төгсгөлд аман шалгалтын үеэр багш, зөвлөх багш нар, шалгалтын комиссын дарга, гишүүдийн өмнө танилцуулна.
- ✓ Төгсөлтийн диплом болон ажиллах-суралцах гэрээ байгуулсны 13 дахь сард оюутнууд компанийн дотоод үйл ажиллагааг хэрхэн оновчтой болгох үндэслэлээ дипломын ажлаараа танилцуулдаг бөгөөд тэдний хувьд онол, практикийг холбох боломж юм.

Грекийн University of Macedonia их сургуулийн туршлага:

- ✓ Грек улсын сайд нарын 2017 оны 2 сарын 16-ы өдрийн 26385 тоот хамтарсан шийдвэрийн 1-р зүйлд зааснаар “АБСС-ын тогтолцоо гэдэг нь оюутныг сургууль, ажлын байрны хооронд ээлжлэн суралцуулах боловсролын тогтолцоо юм” гэж тодорхойлжээ (Gazette сэтгүүлийн 2017 оны 02 сарын 20-ы дугаарын 491/Б тал)”.
 ✓ Тус сургууль нь 1994 оноос Career Office (CO)-оор дамжуулан АБССХ-ийг хэрэгжүүлж байна.
- ✓ Дадлагын асуудал харицусан төв (ДАХТ)
- ✓ Мөн дараах төвүүдээр байгууллагууд хамтран оролцдог байна.
 - Дадлагын төв
 - Ажил эрхлэлт, мэргэжил зохион байгуулалтын алба (DASTA Office)
 - Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх төв, хөдөлмөрийн зах зээл, дадлага энтрепренёршип чиглэлээр оюутныг дэмжих төв инновац, энтрепренер хариуцсан төв
- ✓ АБССХ-ийн дадлагын хугацаа нь 2-3 сар бүтэн цагийн ажилтнаар хийдэг нь оюутнууд ажлын бус цагаар ажиллах боломжгүй байна гэсэн гомдол гаргадаг байна.

Мөн АБССХ-ийг Азийн бүс нутгийн улсууд хэрэгжиж буй бодлого зохицуулалтын талаар тэр дундаа урд хөрш болох Хятад улсын туршлагын талаар энэхүү судалгааны ажилдаа дэлгэрэнгүй орууллаа. (Хүрэлбаатарын ХЭРЛЭН бусад, 2023, pp. 5-8)

Хятад улсын АБССХ-ийн талаарх туршлага:

Хятадын засгийн газар үйлдвэрлэл, технологийн салбар дахь ур чадварын хомсдол руу бодлогоо хандуулж эхлээд байна. Хятад шинж чанартай орчин үеийн ажлын байранд сургах шинэ арга замыг эрэлхийлээд дараах хоёр байгууллага нь хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

- Боловсролын яам
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Тус улсад АБССХ-ын суралцагчдын хамгийн эхний давуу тал нь ажилчны статустай цалинждаг ба хоёрдугаарт ажлын байранд сургах харилцааг ажил олгогч, суралцагч хоёрын хооронд байгуулсан гэрээ эсвэл албан ёсны хэлэлцээрт үндэслэн байгуулдаг. Зарим тохиолдолд боловсрол, сургалтын байгууллагатай гэрээ байгуулдаг байна. АБССХ нь оюутан болон байгууллагад хэд хэдэн давуу талуудыг бий болгодог.

1. АБССХ нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэх, сургуулиас ажлын байранд жигд шилжих
2. Шууд ажилтан авахаас ажлын байранд сургаж авч байгаа нь эдийн засгийн хувьд өгөөжтэй мөн ажилтан авах цагийг хэмнэх давуу талуудийг бий болгосон.

Тус улсын сүүлийн үеийн АБССХ-ийн туршилтуудаас:

Хятад улс 2014 онд Боловсролын яамнаас "Орчин үеийн АБСС-ын туршилтын төслийг хэрэгжүүлэх зөвлөмж" баримт бичгийг гаргаж хэрэгжүүлэн туршсан. Ингэхдээ дараах 2 зүйлийг чухалчилж тавьсан.

1. Оюутнуудыг АБССХ-төлбөрт элсүүлэх үйл ажиллагааг идэвхижүүлэх,
2. Аж ахуйн нэгжүүдийг урамшуулах

Энэхүү төслийг хэрэгжүүлэхдээ мөн 3 гол зорилго тодорхойлон хэрэгжүүлсэн байна.

1. Ажилд авах төлөвлөгөөг хамтран гаргах, сургууль, аж ахуйн нэгжүүдийн хоорондын уялдаа холбооны заавар гаргах, ур чадвар сайжруулах сургалтыг хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах,
2. “Ажлын байран дахь сургалт” загварт шинэчлэлийг хийх;
3. Сургуулийн багш нар, аж ахуйн нэгжийн менторуудаас бүрдсэн багшлах боловсон хүчнийг бэхжүүлэх, орчин үеийн АБССХ-ийг гаргах.

АБСС-ын туршилтын төлөвлөгөөг нь боловсролын сургалтын байгууллагууд голчлон хэрэгжүүлж, аж ахуйн нэгжүүд нэмж өөрчлөлт оруулсан байна. 2015 оноос шинэчилсэн АБССХ-ийг боловсруулж эхэлсэн ба Боловсролын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаар дамжуулан 22 мужаас 5 том үйлдвэрийг хамруулан сургалтын хугацааг 1-2 жил, зарим онцгой тохиолдолд 3 жил үргэлжлүүлсэн. Ментороор ажиллаж байгаа багш нарыг уян хатан нөхцөлтэй зээлд хамруулах, оюутнуудад олгох цалингийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоох, аж ахуйн нэгжүүдэд оюутнуудын цалингийн зардлын шимтгэлд засгийн газраас санхүүгийн татаас өгөх зэргээр дэмжин хэрэгжүүлсэн. Менторууд байгууллагаасаа тэтгэмж авах боломжтой. Хятад улс АБССХ-ийг дараах байдлаар бүсчлэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. БНХАУ-ын АБССХ-ийн хэрэгжүүлэн үе шатууд

Үе шатууд	Туршилтын мужууд	
Эхний үе шат 2015 оны 7-р сар	12 мужууд	Бээжин хотын захиргаа, Тяньжин хотын захиргаа, ӨМӨЗО, Ляонин муж, Шанхай хотын захиргаа, Жянсу муж, Шаньдун муж, Хэнань муж, Гуандун муж, Чунцин хотын захиргаа, Ганьсу мужийн Сычуань муж
Хоёрдугаар үе шат 2016 оны 7-р сар	10 мужууд	Хэбэй муж, Шаньси муж, Жилин муж, Хармөрөн муж, Жэжян муж, Фужиан муж, Жянши муж, Хубэй муж, Гуанси Жуан Автономит Бүс, Юньнань муж

Эх сурвалж: (Liu Chen, Zhiqun Zhao, Yuqi Chen, 2019)

Энэхүү хөтөлбөрийн туршлагаас үүдэн 2018 оноос байгууллагаар удирдуулсан АБССХ-ийг албан ёсоор хэрэгжүүлэх зөвлөмжийг гаргажээ. Ингэхдээ сургуулиадад татаасын 50%-ийг эхэнд нь шилжүүлж дууссаны дараа үлдэдлийг шилжүүлэхээр заасан. Хөтөлбөр нь даалгаварт суурилсан заах арга барилыг хэрэгжүүлж, сургалтын даалгавруудыг “сургалтын үндсэн даалгавар”, “үйлдвэрлэлийн сургалтын ерөнхий даалгавар”, “аж ахуйн нэгжийн

сургалтын даалгавар” гэсэн гурван ангилалд хуваасан байна. Хөтөлбөрт оролцогч нь ажлын байранд дадлагжих хугацаандаа хичээлээ судлах боломжтой.

Туршилтын хөтөлбөр нь дараах дарааллын дагуу зургаан 7 хоногт явагдаж байсан.

- ✓ Эхний 7 хоногт сургууль, аж ахуйн нэгжийн хичээлийн харьцаа 4:1, энэ хугацаанд сургуулийн багш нар илүү үүрэгтэй оролцоно.
- ✓ Хоёрдугаар 7 хоногт нь хөтөлбөрийн талаарх сургалт ба сургуулийн онолын сургалт 2:3 харьцаатай бөгөөд аж ахуй нэгжийн ментор нь үндсэн багш.
- ✓ Гуравдугаар 7 хоногт ажлын байранд 4 өдөр ажиллах ба 1 өдөр сургууль дээр онолын сургалтыг үзэх
- ✓ Дөрөвдүгээр 7 хоногт аж ахуйн нэгжүүд ажлын байран дээрх сургалт зохион байгуулдаг байна. Ингэснээр оюутнууд олон ажил хийх сургалтын үйл явцыг биеэрээ мэдэрдэг.
- ✓ Тав болон зургаа дахь 7 хоногт оюутан үйлдвэрт ажлын байранд ажиллана.

Хятад улс нь АБССХ-ийг амжилттай хэрэгжүүлсэн Германы туршлагад үндэслэн хос сургалтын системийг нутагшуулахыг оролдож байгаа. Гэхдээ энэ нь тийм хялбар биш ба соёл, институцийн харилцан уялдаа холбоо нь Германы амжилтыг нутагшуулахад гол саад болж байна. Хятадын төрийн байгууллагуудын хийсэн АБССХ нь сайшаалтай байгаа хэдий ч оролцогч талууд бодлогоо илүү тодорхой, нээлттэй, хэрэгжүүлэхийг оюутнууд шаардаж байна.

АБССХ-ийг цаашид хэрэгжүүлэхийн тулд нэг сургууль 20-иос доошгүй аж ахуйн нэгжтэй, нэг аж ахуйн нэгж ч цөөнгүй сургуультай хамтын ажиллагааны харилцаа тогтоох шаардлага үүсээд байна. Үүнээс гадна хамтын ажиллагааны платформыг бий болгох эрэлт хэрэгцээтэй байгаа тул "One versus One" хөтөлбөр буюу нэг сургууль нэг байгууллалтай хамтарч ажиллах нь өндөр өртөгтэй, үр ашиг багатай байна. Мөн сургууль, аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг дэмжихийн тулд хяналт, зохицуулалт хариуцсан хөндлөнгийн байгууллага байгуулах шаардлага мөн гарсан байна. Хэдийгээр АБССХ нь боломжит ажилчдыг шалгах, ажил олгогчийн тусгай ур чадварыг хөгжүүлэх зэрэг эдийн засгийн асар их үр өгөөжийг авчирдаг ч компаниуд ажлын байран дээрх сургах ажилд оролцох сонирхол бага, сургууль, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа өнгөцхөн хэвээр байсаар байна. Нэг талаас, аж ахуйн нэгжүүд эдгээр хамтын ажиллагааг зөвхөн ажиллах хүчний хомсдолыг шийдвэрлэх аргаар харж байгаа нь зарим оюунтуудыг "хямдхан ажиллах хүч" болгон хувиргах сөрөг талтай. Энэ нь оюутнуудын эрх ашгийг зөрчиж, аж ахуйн нэгжүүд оюутнуудын мэргэжлийн карьерын өсөлт хөгжилд анхаарал хандуулахгүй талтай байгаа нь харагдлаа. Харин сургууль талаас аж ахуй нэгжүүдийн шаардлагад нийцэхүйц ажиллах хүчин гаргадаггүй нь онолын мэдлэг, практик үйл ажиллагааны хооронд ан цав байсаар байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Азийн бүс нутгийн улсуудын бодлого зохицуулалт


Улсын нэр	Хятад	Энэтхэг	Филиппин	Тайланд	Монгол-СЭЗИС
Хууль эрх зүйн орчин	Төрөөс бодлогоор дэмждэг	1961 онд батлагдсан	Ажил эрхлэлтийн хүрээнд хийх сургалт	Хууль зүйн орчингүй	Хууль эрх зүй орчингүй
ААН-д тавигдах шаардлага	10% хүртлэх	2%-5%	20% хүртлэх	20% хүртлэх	Жилд +20 оюунтан хамруулах
Цалингийн хэмжээн	Хамгийн бага хэмжээ жилд 4000 CNY-с багагүй	1 жилд-70%, 2 жил-80%, 3 жилд-90%	Хөдөлмөрийн хөлсний доод 75%-иас доошгүй	Хөдөлмөрийн хөлсний доод 50%-иас доошгүй	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр
Хугацаа	1-2 жил	3-36 сар	3-24 сар	3-24 сар	6 сар
Төрөөс дэмжих бодлоготой	Боловсрол, Хүний нөөц нийгмийн хамгааллын яам	Салбарын ур чадварын зөвлөлтэй	Техникийн боловсрол, ур чадварын хөгжлийн газар (TESDA)	Хөдөлмөрийн яам /Ур чадвар хөгжүүлэх газар/	Erasmus+ MONGWBL

Эх сурвалж: (Swiss Foundation for Technical Cooperation, 2019)

II. БҮЛЭГ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны дизайн

Зураг 2. Судалгааны дизайн



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

2.2 Судалгааны арга зүй

СЭЗИС-ийн АБССХ-ийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор санал, асуулга авлаа. Тус судалгааны ажлаар дараах зүйлсийг тодруулахыг зорин ажиллаа. Үүнд:

1. АБССХ хөтөлбөрт хамрагдсан оюутны ур чадвар, сэтгэл ханамжийг тодорхойлох

2. Удирдагч багш болон сургуулийн зохицуулагчаас хөтөлбөрийн үр дүнтэй байдал болон стандарт хэрэгжилтийг тодорхойлох
3. Оролцогч талуудад тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлох
4. АБССХ-ийн үйл ажиллагаанд цаашид тусган ашиглахуйц зөвлөмж дүгнэлтийг судалгааны үр дүнд түшиглэн боловсруулах.

Судалгааны хамрах хүрээ

АБССХ-ийн оролцогч талууд:

1. АБССХ-т хамрагдсан СЭЗИС-ийн нийт 20 оюутан
2. АБССХ-ийн удирдагч багш – 5 багш
3. АБССХ-ийн зохицуулагч судалгаанд хамрагдсан.

Судалгааны мэдээлэл цуглуулах арга

Бид энэхүү судалгааны мэдээлэл цуглуулалтыг дараах стандарт аргачлалуудаар хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Биечлэн уулзалт
- Фокус бүлгийн ярилцлага
- Санал асуулгыг утас болон Гүүгл формс

Ш. БҮЛЭГ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

2.1 Монгол улсын дээд боловсролын салбарт АБССХ хэрэгжиж буй өнөөгийн байдал

2022 оны 03 сарын 25 өдөр Монголын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилго бүхий ERASMUS+MONGWBL төслийн хэлэлцүүлэгт Боловсрол, Шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар, Европын холбооны төлөөлөлгчийн газар, Отгон тэнгэр их сургуулийн удирдлага оролцож, ХБНГУ, Франц, Румын, Грекийн их сургуулиудын туршлагаас суралцан Монголд улсын онцлог нөхцөлд тохирсон Ажлын байранд суурилсан жишиг сургалтын нэвтрүүлж, төгсөгчдийн ажил мэргэжлийн бодит үр чадварыг олгохоор ажил олгогчтой хамтран ажиллаж байгаагаарай ихээхэн онцлогтой үр өгөөжтэй хэлэлцүүлэг болсон. Хэлэлцүүлэгт БШУЯ, Отгонтэнгэр их сургууль, ХААИС, СЭЗИС, Дорнод ИС, СУИС, Голомт болон Төрийн банк, Монголын аялал жуулчлалын холбооны төслийн багийн гишүүд болон Монголын ИДС-ийн профессор, судлаачид, ажил олгогчдын 120 төлөөлөл хамрагдлаа. (БШУЯ, 2022)

Ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэх ERASMUS+ MONGWBL төслийн чадавч бэхжүүлэх сургалтыг ХБНГУ-ын Берлиний Эдийн засаг, хуулийн сургууль, Франц улсын Люмир Лион 2 их сургууль, Румын улсын Транселваны их сургууль, Грек улсын Македоны их сургуулийн профессорууд удирдан явуулж, сургалтад БШУЯ-ны удирдлага, мэргэжилтнүүд, төслийг хамтран хэрэгжүүлэгч СЭЗИС, ОТИС, СУИС, ХААИС, Дорнод их сургуулиудын удирдлага, багш оюутнууд, Голомт болон Төрийн банкны хүний нөөцийн газар, хэлтсийн удирдлага мэргэжилтнүүд оролцсон. (ХААИС, 2022)

ERASMUS+MONGWBL төслийн хүрээнд өнөөг хүртэл хийгдсэн ажлууд:

2022 оны 05 сарын 31 Монголын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх MONGWBL төслийн аялал жуулчлалын хөтөлбөрийн ажлын байранд суурилсан сургалтын жишиг хөтөлбөрийг танилцуулах хэлэлцүүлэг СЭЗИС дээр болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. (СЭЗИС, 2022)

2022 оны 06 сарын 10 FAM хэлэлцүүлэг Банк болон Даатгалын хөтөлбөр Голомт банк, Төрийн банктэй хамтарч хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгээр Erasmus+ Монголын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь (MONGWBL) төсөл хамтран хэрэгжүүлж, Монгол улсын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл бодлого боловсруулсан. Тус бодлогод оролцогч талууд болон үнэлгээний арга, сургалтын стратеги, гурван талт гэрээ гэх мэт АБСС (WBL)-ыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай үе шат, үндсэн чиглэлийг тусгасан. (Erasmus+MONGWBL, 2023)

WPL хөтөлбөр нь манай улсад шинээр хэрэгжиж эхлэх гэж буй хөтөлбөр ба СЭЗИС-н зүгээс баримт бичгийг эхний байдлаар баталсан байна.

СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн ажлын байранд суурилсан сургалт зохион байгуулах журам боловсруулж баталсан. (СЭЗИС, СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн АБСС зохион байгуулах журам, 2022)

2022 оны 09 сарын 19-21 өдрөөс 3 өдрийн турш Дээд боловсролын тогтолцоонд АБСС-г нэвтрүүлэх ERASMUS+MONGWBL төслийн чиглүүлэх сургалт 2 үе шаттайгаар зохион байгуулагдав. Сургалтын эхний хагаст оролцогч талуудыг төлөөлж Төрийн банк, Аялал жуулчлалын холбоо тухайн салбарт тулгамдаж буй асуудал-ын талаар хэлэлцүүлэг өрнөсөн бол 2-р үед Банк болон Аялал жуулчлалын хөтөлбөрийн багш, оюутан, мэргэжилтнүүд 2 багт хуваагдаж АБСС- зорилгод хэрхэн хүрэх, үнэлгээг хэрхэн зохион байгуулах оюутнуудыг аж ахуй нэгж байгууллагад ямар давтамжтайгаар гаргах гэх мэт зохион байгуулалт, үйл явцын талаар ярилцаж, багууд сургалтын үр дүнгээ танилцуулж, нэгдсэн зохион байгуулалтад орлоо. (Монголын үндэсний телевиз, 2022)

2022 оны 09 сарын 30 өдөр тус төслийн хүрээнд Банк даатгалын хөтөлбөрөөр АБССХ-т хамрагдах оюутнууд хүлээн авах бэлтгэлээ хангаж Голомт банкны хүний нөөц удирдлага, мэргэжилтнүүд СЭЗИС болон Отгонтэнгэр сургуулийн оюутнуудад чиглүүлэх сургалт зохион байгуулсан. (Erasmus+MONGWBL, 2023)

2022 оны 10 сарын 27 Төрийн банкны баг Банк Даатгал хөтөлбөрөөр АБССХөтөлбөрийг ОТИС болон СЭЗИС-оюутнуудтай уулзаж, төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлэлт дэлгэрүүлэлтийн талаар уулзалт зохион байгуулсан.

2023 оны 01 сарын 17-ны өдөр СЭЗИС болон ОТИС-н “Банк даатгал” хөтөлбөрийн оюутнууд Голомт банк дээр АБССХөтөлбөрт 3 сарын хугацаанд хамрагдаж байгаа оюутнуудын сургалтын үйл явцын эхний үе шатны тайлан хамгаалалтыг Голомт банкны төслийн баг зохион байгуулж энэ хугацаанд эзэмшсэн ур чадвар, хэрэгжүүлсэн ажил, үүрэг, гүйцэтгэл шинэ санаа, санаачилга гэсэн агуулгын хүрээнд тайлангаа хэлэлцүүлж Голомт банкны салбар, хэлтэс хариуцсан ажилтнууд үнэлгээ дүгнэлт өгсөн. (Төрийн банк, 2023)

2023 оны 3-р сарын 27-29-ний өдрүүдэд ХБНГУ-д “Ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн ээлжит сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Тус сургалтанд Монгол улсаас MONGWBL төслийн нийт 50 оролцогч оролцсон бөгөөд Франц, Грек, Румын улсаас зургаан оролцогч оролцсон. Сургалты эхний өдөр Герман, Франц, Грек, Румын улсын оролцогчид өөрсдийн АБСС-ын хөтөлбөрийн сайжруулсан туршлагаа хуваалцсан бол сүүлийн өдрүүдэд Монголын оролцогч хамтрагчид АБСС-ын хөтөлбөрийн туршин хэрэгжүүлэх явцыг БШУЯам болон зохицуулагч сургуулийн төлөөлөгчид боловсруулж буй үндэсний бодлогын бичиг баримт, зураглалыг тус тус танилцуулж Европын холбооны хамтрагч сургуулиудын профессор, мэргэжилтнүүдээс сайжруулалт санал зөвлөмж авч амжилттай оролцсон. (СЭЗИС, UFE, 2023)

СЭЗИС нь Европын холбооны Erasmus плас төслийн сайн туршлагыг хэрэгжүүлэхээр БШУЯ, Отгонтэнгэр их сургууль, ХААИС, СУИС, ИС, Голомт банк болон Төрийн банк, Монголын аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллаж байна. (СЭЗИС, UFE, 2023)

2.2 СЭЗИС-д АБССХ хэрэгжиж буй өнөөгийн байдал

СЭЗИС-ийн 2021-2031 стратегийн шинэ зорилгын хүрээнд бакалаврын хөтөлбөрийн шинэчлэлийг “ Бакалавр 2.0” нэртэйгээр хэрэгжүүлж байна. (СЭЗИС, Бакалаврын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлж байна, 2022)

- ✓ “Бакалавр 2.0” хөтөлбөрийн шинэчлэлд дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
Үүнд:
- ✓ Хос, хавсарга мэргэжил эзэмших боломж
- ✓ Олон улсын хамтарсан хөтөлбөрийн шинэчлэл
- ✓ Олон улсын мэргэшсэн зэргийн хөтөлбөр
- ✓ Ажлын байранд суурилсан хөтөлбөр
- ✓ Мэргэжлийн шинэ хөтөлбөрүүд
- ✓ Энтрепренер хөтөлбөр
- ✓ Гадаад хэлний хөтөлбөрийн шинэчлэл
- ✓ Дижитал ур чадвар
- ✓ Сургалтын уян хатан зохион байгуулалт
- ✓ Оюутны хөгжлийн бодлого (СЭЗИС, СЭЗИС-ийн Бакалаврын хөтөлбөрийн шинэчлэл “UFE BACHELOR 2.0”-ийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа, 2022)

2022 онд оюутнуудын карьер хөгжлийг дэмжих зорилгоор сургуулийн бакалаврын хөтөлбөрийн хүрээнд “Оюутны хөгжлийн бодлого” батлан, хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна. Тус бодлогын нийтлэг зүйлд “Оюутны төлөвшил, хувь хүний болон карьер хөгжлийг дэмжих” гэж тусгайлан зааж, дараах 5 чиглэлийг тодорхойлсон. (СЭЗИС, 2022)


Зураг 3. Оюутны хөгжлийн бодлогын чиглэл



Эх сурвалж: (СЭЗИС, 2022)

Үүний нэг хөтөлбөр нь Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр юм. СЭЗИС нь Erasmus + MONGWBL төсөлтэй хамтран ажиллаж тус төслийн хүрээнд Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг Отгонтэнгэр их сургуультай хамтран Банк, Даатгал, Аялал жуулчлалын бакалаврын хөтөлбөрт тус тус хэрэгжүүлж байна.

Зураг 4. АБСС-н оролцогч талуудын харилцааны схем




Эх сурвалж: МУ-ын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэврүүлэхэд баримтлах чиглэл

СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн ажлын байранд суурилсан сургалт зохион байгуулах журмын хүрээнд тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Тус журамд тусгагдаагүй болон зохицуулагдаагүй асуудлыг СЭЗИС-ийн ректорын тушаал, сургалт судалгаа хариуцсан проректорын шийдвэрээр зохицуулагдаж байна.

Хөтөлбөрийн зохион байгуулалт:

- ✓ Ажил олгогч болон болон сурууль хооронд албан ёсны хамтын гэрээ, хэлцэл хийж баталгаажуулж хэрэгжүүлж байна.
- ✓ АБСС-ын дадлага нь 20 кредит байх бөгөөд бакалаврын сургалтын төлөвлөгөөний нийт кредитэд багтсан байна. Дадлагын кредит болон үнэлгээг кэйс сургалт, бизнесийн дадлага, мэргэжлийн дадлага, төгсөлтийн шалгалт (диплом), бусад мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдийн дүнд дүйцүүлнэ.
- ✓ Төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлүүдийг үзэж судалсан 3 болон төгсөх курсын оюутныг нийт 6 сарын хугацаанд цалинтай дадлагажиж байна.
- ✓ Хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутнууд бусад нэмэлт кредитийн хичээлийг бямба гараг болон цахим хэлбэрээр суралцаж, өдрийн хөтөлбөрөөр хичээл судлахгүй зохицуулалт хийж байна.

Зураг 5. АБССХ-ийн оролцогч талуудын одоогийн процессын зураглал



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд АБСС-ийг нэвтрүүлэх ERASMUS+ MONGWBL төслийн хүрээнд нэвтрүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх СЭЗИС-ийн “Банк даатгал”-ын хөтөлбөрийн оюутнууд Голомт банк болон Төрийн банкинд АБССХ-ийг хэрэгжүүлж байна. (Голомтбанк, 2022) Төрийн банкинд 2022 оны 10 сарын 03 өдрөөс банк даатгалын хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудыг хүлээн авснаар АБССХ-ийг албан ёсоор эхлүүлсэн. Уг хөтөлбөрийн хүрээнд Голомт банк, Төрийн банкинд “банк,

даатгал"-ын чиглэлээр суралцаж байгаа 20 оюутан АБССХ-ын чиглүүлэх сургалтанд хамрагдаж, мэргэжлийнхээ чиглэлээр мэдлэг чадвар эзэмшиж, мэргэжлийн банкируудаас заавар зөвөлгөө авч үндсэн ажилтны адил цалинтай ажиллаж байна.

Одоогийн байдлаар Голомт болон Төрийн банкинд нийт 2 ээлжийн 20 оюутан тус хөтөлбөрт хамрагдаж байна. Үүнд 1-р ээлжийн 10 оюутны 5 нь Голомт банкинд, 5 нь Төрийн банкинд, 2-р ээлжийн 10 оюутан бүгд Голомт банкинд дадлагажиж байна.

1-1-р ээлж нь 2022 оны 10 сарын 03-ны өдрөөс 2023 оны 03 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг хамрах бол 2-р ээлж нь 2023 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааг хамарч байна. Оюутнууын хөтөлбөр болон тухайн ээлжинд хэдэн оюутан хамрагдаж буйг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 4. Хөтөлбөрт хамрагдаж буй оюутны тоо (байгууллагаар)

Хамрагдаж буй оюутны тоо		Голомт		Төрийн банк		Нийт
		1-р ээлж	2-р ээлж	1-р ээлж	2-р ээлж	
		5	10	5	0	20
Хөтөлбөр	Банк	5	5	4	-	14
	Санхүү	-	5	1	-	6

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

АБССХ-г хамрагдаж байгаа оюутнууд 5-9 хичээлийн нийт 20 кредит дүйцүүлэх боломжтойгоор хэрэгжиж байна. Ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь" төслийн хүрээнд СЭЗИС-ийн "Банк даатгал" хөтөлбөрийн оюутнууд Төрийн банк дээр Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрт хамрагдаад 3 сарын хугацаа өнгөрч, тус хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутнуудын сургалтын үйл явцын эхний үе шатны тайлан хамгаалалтыг Төрийн банкны төслийн баг зохион байгуулж, тайлан хамгаалалтад оюутан бүр 3 сарын хугацаанд эзэмшсэн ур чадвар, хийж хэрэгжүүлсэн ажил, үүрэг, тулгамдсан сорилт бэрхшээл, түүнийг даван туулсан арга зам, цаашид дэвшүүлэх шинэ санаа, санал санаачилга гэсэн агуулгын хүрээнд тайлангаа хэлэлцүүлж Төрийн банкны салбар, хэлтэс хариуцсан албан тушаалтнууд үнэлгээ, дүгнэлт хийсэн. Эхний 3 сард оюутнууд банкны салбар тооцооны төвд ажиллаж дадлагажсан бол дараагийн 3 сард банкны төв албанд дараах албан тушаалд цалинтай дадлагажиж 2023 оны 4 сарын 7-нд тайлан хамгаалалт болж дууссан.

Хүснэгт 5. Хөтөлбөрт хамрагдаж буй оюутны дадлагажиж буй албан тушаал

Тоо	Банк	Хөтөлбөр	Алба хэлтэс - Албан тушаал
1-р ээлж			
1	Төрийн банк	Банк	Эрсдэлийн удирдлагын газар, Мэргэжилтэн
2		Банк	Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн газар, Мэргэжилтэн
3		Банк	Хөрөнгө зохицуулалтын газар, Мэргэжилтэн
4		Санхүү	Комплаенсийн газар, Мэргэжилтэн
5		Санхүү	Комплаенсийн газар, Мэргэжилтэн
6	Голомт банк	Банк	ИБГ-БХ-Утсан борлуулалтын алба
7		Банк	Дижитал банкны газар картын хэлтэс
8		Банк	Зээлийн газар
9		Банк	Хүний нөөцийн удирдлагын газар
10		Банк	Яармаг салбар ХҮА
2-р ээлж			
11	Голомт банк	Санхүү	Утсан борлуулалтын алба, Борлуулалтын ажилтан
12		Санхүү	Баянзүрх салбар, Харилцааны менежер
13		Санхүү	Цамбагар бизнес төв, Харилцааны менежер
14		Банк	Утсан борлуулалтын алба, Борлуулалтын ажилтан
15		Банк	Сонголон тооцооны төв, Харилцааны менежер
16		Банк	Нисэх салбар, Харилцааны менежер
17		Санхүү	Хан-Уул И-март салбар, Харилцааны менежер
18		Банк	Утсан борлуулалтын алба, Борлуулалтын ажилтан
19		Банк	Утсан борлуулалтын алба, Борлуулалтын ажилтан
20		Санхүү	Утсан борлуулалтын алба, Борлуулалтын ажилтан

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

"Ажлын байранд суурилсан сургалт"-ын 2-р шатны дадлагыг 1-р үе шатны дадлагын ажлын үнэлгээ болон тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг үндэслэн томилдог.

АБССХ нь аялал жуулчлалын тэнхимд аль хэдийн хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоо эрх зүйн тэнхим болон мэдээлэлийн системийн тэнхимүүдэд хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Эрх зүйн тэнхим: АБССХ-г хэрэгжүүлэхээр Монгол Улсын арбитрай гэрээ байгуулсан. Арбитр зардлыг ирэх жилийн төсөвтөө суулгах талаараа мэдэгдсэн. 2023 оны 9 сараас дадлагажих оюутны сонгон шалгаруулалт хийгдэхээр төлөвлөгдөж байна.

Мэдээллийн системийн тэнхим: М Банк, Ашид капитал ББСБ-тай гэсэн байгууллагуудтай гэрээгээ байгуулсан бөгөөд хөтөлбөрт оюутнуудын бүртгэл эхлэх шатандаа явж байна.

Аялал жуулчлалын тэнхим: Тус тэнхимийн оюутнууд 2022 оны 09 сард чиглүүлэх сургалтанд хамрагдаж 1 модуль 3-4 хичээлийн нийт 18-20 кредит дүйцүүлж, 8, 8 долоо хоног буюу модулийн системээр АБССХ-т хамрагдаж байна. Тус хөтөлбөрт аялал

жуулчлалын 3,4-р курсын 20 оюутнууд хамрагдаж байна. Япон улсад 14 оюутан 1 жилийн хугацаанд, 15 оюутан Монголдоо тэргүүлэх тур оператор, жуулчны бааз, аялалын компани, үйлчилгээний 8 газарт цалинтай дадлагажиж, ажил олгогчдын тавьж буй шаардлага нийцсэн ур чадварт суралцан хөдөлмөрийн зах зээлд чанартай боловсон хүчин болоход бэлтгэгдэн дадлагажиж байна. 1 жилд 4 модуль хэрэгжиж байна.

Хүснэгт 6. Аялал жуулчлалын тэнхимийн АБССХ-ийн хичээлүүд

№	1 модуль	Кредит	Оюутан хөгжлийн үнэлгээ, мэргэжлийн чадамжийг гүйцэтгэл
	Хичээлийн нэр		
1	Аялал жуулчлалын бизнес шинжилгээ	2	Хичээлийн кредит багц цаг бүрэн судалсан байх , судалгаа, төслийн үнэлгээ, зөвлөгөө хийсэн байх, судалгааны төсөл бичиж хамгаалах / тайлан хамгаалалт
2	Аялал жуулчлалын бизнес загварчлал	2	
3	Аялал жуулчлалын бизнес төлөвлөгөө	2	
4	Аялал жуулчлалын бизнес загварчлал, хөгжүүлэлт /Аялал жуулчлалын байгууллагын жишээн дээр /	Тооцох	

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Оюутнууд тухайн газраа календарьчилсан ажлын төлөвлөгөө гаргаж түүнийхээ дагуу шаардах ур чадвар, ямар хугацаанд ажлын байр солигдох гээд нарийн төлөвлөгөө гарган дадлагажиж байна. Түүнийхээ дагуу дадлагын ажлын тайлан бичиж хамгаалдаг. Япон улсад дадлагажиж байгаа оюутнууд тайлан хамгаалалтаа цахимаар танилцуулж чиглүүлэгч багшийн үнэлгээг 70%-д харгалзан үзэж хичээлийн дүнг тусгаж байна. Эхний тайлан хамгаалалтууд 2023 оны 2 сарын 2-нд болж өндөрлөсөн. Дараагийн тайлан хамгаалалтууд 2023 оны 5 сарын 26-27 өдрүүдэд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн явж байна. (СЭЗИС, UFE, 2023)

2.3 СЭЗИС-ийн карьерийн үйлчилгээг хэрэгжүүлж буй өнөөгийн байдал

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль нь карьерын үйлчилгээг карьер хөгжлийн төв, оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв, сургалтын алба, сургуулийн вебсайт, оюутны дотоод сайт, социал хуудсуудаараа дамжуулан оюутнууддаа хүргэдэг.

Хүснэгт 7. СЭЗИС-ийн вебсайт дээрх карьер үйлчилгээний хэсэг

Утга	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
Линк	https://www.ufe.edu.mn/
Үндсэн цэс	Бидний тухай - Төгсөгч Оюутны амьрал - Оюутны холбоо - Тэтгэлэг Мэдээлэл

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Сургуулийн хувьд тусдаа карьер үйлчилгээний сайтгүй бөгөөд сургуулийн үндсэн вебсайтад Бидний тухай хэсэгт сургуулийн танилцуулгаас гадна Төгсөгчдийн мэдээллийг байршуулсан байна. Оюутны амьдрал цэсэнд Оюутны холбоо, Тэтгэлэг мэдээллүүдийг тус тус байршуулсан байна. Мөн цаг үеийн шинжтэй бүхийл мэдээ мэдээллүүдээ Мэдээлэл цэсэнд идэвхитэй байршуулж түгээдэг.

2022 онд оюутнуудын карьер хөгжлийг дэмжих зорилгоор сургуулийн бакалаврын хөтөлбөрийн хүрээнд “Оюутны хөгжлийн бодлого” батлан, хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна. Тус бодлогын нийтлэг зүйлд “Оюутны төлөвшил, хувь хүний болон карьер хөгжлийг дэмжих” гэж тусгайлан зааж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байранд бэлтгэх чиглэлийн хүрээнд дараах ажлуудыг тодорхойлсон.

Зураг 6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байранд бэлтгэх чиглэлийн хүрээнд хийгдэх ажлууд

5.1 Ажлын байранд бэлтгэх сургалт	5.2 Хөдөлмөр зуучлалын үйлчилгээ
<ul style="list-style-type: none">- Албан харилцааны соёл- Карьер хөгжил- CV, товч намтар бичих- LinkedIn хэрэглээ- Ажлын байрны сонгон шалгаруулалтын ярилцлаганд бэлтгэх	<ul style="list-style-type: none">- Ажил олгогч байгууллагуудын дадлага, цагийн болон үндсэн ажлын байрны мэдээллийг оюутанд хүргэх, зуучлах, мэдээллийн сан үүсгэх- Ажил олгогч байгууллагуудтай хамтран ажилын байрны үзэсгэлэн яармаг зохион байгуулах- Төгсөгчдийг мөшгөх судалгаа хийн, ажлын байр идэвхтэй хайж буй төгсөгчдийг ажлын байранд зуучлах

Эх сурвалж: Оюутан хөгжлийн бодлого

Дээрхээс гадна оюутны карьер хөгжлийг дэмжих зорилгоор үйл ажиллагаа, хөтөлбөр, уулзалтуудыг мөн зохион байгуулан ажилладаг бөгөөд эдгээрийг Сургалтын нэгдсэн хуанлид Үндсэн хамтарсан хөтөлбөр, Цагийн хөтөлбөр, Оюутны хөгжил, Багшийн хөгжил гэсэн бүлгээр тус бүрд нь гаргасан байдаг. Үндсэн хөтөлбөрүүдэд Төгсөгчдийн цуврал уулзалт, Гадаад хэлний шалгалт өгөх зөвлөмж сургалт, Хамтран ажилладаг сургуулиудын уулзалт, Гадаад улс руу зорчихтой холбоотой бэлтгэл ажлыг хангуулах зэрэг арга хэмжээнүүдийг голчлон зохион байгуулдаг. Оюутны хөгжил бүлгийн хувьд оюутны холбоо, хобби клубууд, ментор оюутнууд өдөрлөг, сургалт, зөвлөгөө зэргийг зохион байгуулдаг байна.

Карьер хөгжлийн төв нь карьерын зөвлөгөө, хөдөлмөр зуучийн чиг үүргүүдийг хариуцан оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв, сургалтын албатай хамтран дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Жилд хоёр удаа Ажлын байрны өдөрлөг зохион байгуулдаг. Тус өдөрлөгт 60-70 байгууллага аж ахуйн нэгж оролцдог.
- Карьерын зөвлөгөөг Хөгжлийн семинар бодлогын хүрээнд жилд 8-10 семинарыг төлөвлөн Сургалтын алба оюутнуудын дунд зохион байгуулдаг бөгөөд оюутан тус семинаруудад 50% болон түүнээс дээш ирцтэйгээр оролцох хэрэгтэй болдог.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв ажил горилогчоос ажлын байрны зарыг ufe_connected@edu.mn имэйл хаягаар хүлээн авч, infosys дотоод сайтад зарыг байршуулан оюутнуудын хүсэлтийг цуглуулан буцаан ажил горилогч руу имэйлдэх байдлаар мэдээллээ солилцдог.
- Сайн дурын ажлын бүртгэлийг дотоод сайтаараа дамжуулан хийдэг.

Хүснэгт 8. СЭЗИС-ийн карьер үйлчилгээнд хийсэн SWOT шинжилгээ

Давуу	Сул
<p>Оюутнуудыг ажлын байраар хангах дараах төсөл болон ажлуудыг хэрэгжүүлж эхэлсэн нь сайшаалтай байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Erasmus+Mongwbl төсөл ✓ Ufe Career day ✓ Төгсөгчдийн цуврал уулзалт ✓ Ментор оюутнууд өдөрлөг ✓ Бакалавр 2.0 хөтөлбөрт оюутны хөгжлийн бодлогыг тусгасан. ✓ АБССХ-ийн баримт бичиг баталсан. 	<p>Ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээнүүдэд дараах нийтлэг сул талууд байна.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Мэдээллийг түгээх арга замууд нь өөр өөр ✓ Оролцогч талуудын уялдаа холбоо муу ✓ Нэгдсэн дата сангүй ✓ Үр дүнгийн тайлан мэдээллийн системгүй ✓ Онолын мэдлэг орхигдох ✓ Оюутан цалин, урамшуулалт анхаарал хандуулах
Боломж	Аюул
<ul style="list-style-type: none"> ✓ ОУ-ын түвшинд карьер хөгжлийн туршлагийг хэрэгжүүлэх ✓ Ажлын байранд тавигдах шаардлага болон төгсөгчдийн ур чадварын зөрүүг багасгах ✓ Төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> ✓ Оюутан сургуулиа орхих ✓ Эрх зүйн орчингүй ✓ ААН-үүдийг хамруулах дэмжсэн бодлогогүй ✓ Оюутнуудын хөдөлмөр бодитоор үнэлэгдэхгүй байх

IV. БҮЛЭГ СЭЗИС-ИЙН АБССХ-ИЙН НЭГДСЭН ПЛАТФОРМЫН ШААРДЛАГА ТОДОРХОЙЛОХ НЬ

4.1 СЭЗИС-д АБССХ-ийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал

СЭЗИС-д АБССХ-ийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тулд оролцогч талуудаас судалгаа авсан. Судалгааны үр дүнг нэгтгэж харууллаа.

Хүснэгт 9. Оролцогч талуудад тулгарч буй асуудлууд


№	Оролцогч талууд		
	Оюутан	Зохицуулагч	Удирдагч багш
1	Ачаалал ихтэй - 3-р курсын оюутнууд болон Санхүү хөтөлбөрийн оюутнууд илүү ачаалалтай байгаа нь харагдсан.	Төлөвлөгөө ойлгомжгүй.	Хөтөлбөрийн талаарх мэдээ, мэдээлэл хангалтгүй.
2	Ажлын байрны сонголт хязгаарлагдмал байгаа нь өөрийн хүссэн ажиллаж үзмээр байгаа ажлын байран дээр ажиллах боломжгүй.	Банкнаас заавал зөвшөөрөл авч мэдээллээ дундын файл дээр бусадтай хуваалцдаг байсан.	Оролцогч талуудын уялдаа холбоо муу.
3	Тодорхойгүй байдал ихтэй - Дадлагын тайлангийн үнэлгээ - Дүн - Хугацаа - Цалингийн задаргаа	Төрийн банкинд дадлага хийсэн оюутнууд ажлын байранд сэтгэл ханамжгүй байгаа.	
4	Дадлагын тайлан хамгаалах 1 стандарт байхгүй.	Хичээл зохицуулалт ойлгомжгүй.	
5	Тайлан хамгаалахад дүйцүүлэх хичээлийн агуулгыг бүрэн хамруулж байгаа нь хичээлээ судлаагүй болохоор хүндрэлтэй.	Сургалтын албаруу хүсэлт гаргах процесс төвөгтэй.	
6	Харилцаа холбоо муу Төрийн банкны дадлагын тайлан хамгаалалтанд багш нарт мэдэгдээгүй байсан.		
7	Академик мэдлэг хангалттай авч чадахгүй. Учир нь зарим мэргэжлийн хичээлийг дүйцүүлж байгаа.		
8	Дүйцүүлэх хичээлийн агуулгыг дадлагын тайлан бүрэн хамруулж байгаа нь хичээлээ танхимаар үзээгүй тул тайлан хамгаалахад хүндрэлтэй.		
9	Цалин бага		

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

4.1.1 Хөтөлбөрт хамрагдсан оюутнуудаас авсан судалгаа

АБССХ-т хамрагдаж буй нийт 20 оюутнуудаас судалгаа авахад 17 оюутан буюу 85% нь судалгаанд хамрагдсан байна. Эдгээр 17 оюутнаас 1-р ээлжинд хамрагдаж буй 9 оюутан, 2-р ээлжинд хамрагдаж буй 8 оюутан байснаас тухайн ээлжийнхээ 2-р үе шатанд 13 оюутан буюу 76% нь хамрагдаж байсан. Оюутнуудын 76% нь Голомт банинд 24% нь Төрийн банкинд дадлагажиж байна. (Зураг 7)

Зураг 7. Оюутнуудын дадлажиж буй байгууллага



Зураг 8. Өөрийн хүссэн албан тушаалдаа ажиллаж чадсан эсэх




Оюутнуудын 59% нь өөрийн ажиллахыг хүссэн албан тушаалдаа ажиллаж чадсан бол 41% нь чадаагүй байна. (Зураг 8) Дадлагажихыг хүсэж байсан албан тушаал нь ямар албан тушаал байсан бэ? Яагаад гэсэн асуултыг нээлттэй бичүүлж авсан. Хүссэн албан тушаалда ажиллаж чадаагүй 7 оюутны 5 нь дараах хариултыг илгээсэн байна.

Хүснэгт 10. Ажиллахыг хүссэн албан тушаал

Ажиллахыг хүссэн албан тушаал	Яагаад?
Эрсдэлийн менежер	Карьер төлөвлөгөөний нэг хэсэг
Дотоод аудитор	Багш хичээлээ сонирхолтой заасан
Арын албанд	Өөрийгөө сорьж үзэх
Санхүүгийн менежер	Суралцаж буй мэргэжил учир
Харилцааны менежер	Хийж үзэх сонирхолтой


Оюутнууд ихэвчлэн банкны төв алба буюу арын албанд ажиллах сонирхолтой байгаа нь харагдаж байна.

Зураг 9. Ажлын байран дээрээс эзэмшсэн ур чадварууд



Дадлагад хамрагдсанаар оффисын програмууд, банкны дотоод систем дээр ажиллах чадварууд болон баримт бичиг боловсруулах чадварт илүү суралцсан байна.


Зураг 10. Ажлын байран дээрээс эзэмшсэн зөөлөн ур чадварууд



Зөөлөн ур чадварын хувьд цагийн менежмент, хариуцлагаа ухамсарлах, багаар ажиллах, харилцаа холбоо тогтоох, асуудлыг шийдвэрлэх болон стрессээ удирдах чадварууд нь сайжирсан гэсэн хариултыг өгсөн байна.


Шаардлагатай ур чадваруудыг эзэмшсэн гэж үзэж байна уу? гэсэн асуултад оюутнууд 100% тийм гэсэн хариултыг өгсөн байна. Ажлын байран дээр дадлагажсанаар хатуу болон зөөлөн ур чадваруудаа сайжруулж, өөрт шаардлагатай ур чадваруудыг эзэмшсэн гэж үзэж байна.

Зураг 11. Дараах зүйлсийг үнэлнэ үү. /1-Маш муу, 2-Муу, 3-Дундаж, 4-Сайн, 5-Маш сайн/



Үнэлгээнээс харахад банкны соёл, дадлагын ажил нь тайлангийн сэдэвтэйгээ уялдсан байдал, АБССХ-ийн дундаж үнэлгээ сайн. Харин оролцогч талуудын уялдаа холбоо, дадлагын тайлангийн үнэлгээ дундаж байна.

Зураг 12. Хөтөлбөрөөс ойлгомжгүй, тодорхойгүй зүйлс байсан уу?




59% буюу 10 оюутанд дараах зүйлс ойлгомжгүй байсан байна.

1. Оролцогч талуудын харилцаа холбоо муу
2. Өөрийн дүнгээ мэдэхгүй байгаа
3. Тайлан хамгаах удирдамж, хугацаа тодорхойгүй байсан
4. Диплом хамгаалалт хэзээ гэдэг нь тодорхойгүй
5. Дүйцүүлэх хичээл ойлгомжгүй, хичээлээ хэрхэн зохицуулах нь тодорхойгүй
6. Цалингийн задаргааг харах боломжгүй

Энэ нь оролцогч талуудын харилцаа холбоо муу, оюутнууд мэдээ мэдээллээ хангалттай авч чадахгүй байгаа нь харагдаж байна.


Зураг 13. Тайлан хамгаалалтын үнэлгээ, ил тод ойлгомжтой байсан уу?



Мөн 59% буюу 10 оюутанд тайлан хамгаалалтын үнэлгээ нь ойлгомжгүй, ил тод биш байсан байна. Үүнд:

1. Яаж дүгнэсэн нь тодорх биш
2. Ойлгомжгүй
3. Дүнгийн задаргаа болон үнэлгээг асууж тодруулах шалтгааныг хэлэхгүй нууцлах зэрэг асуудлууд байсан байна.


Зураг 14. . Ментор нь мэдээллээр хэр хангаж байсан бэ?



Ментор буюу ажиллаж байсан алба/хэлтэсийн удирдах албан тушаалтан нь оюутнуудыг байнга тусалж дэмжиж, даалгавар өгч буцаан шалгаж байсан нь харагдаж байна.


Судалгаанд хамрагдсан нийт оюутнууд буюу 100% бүтэн цагаар ажил хийгээд хажуугаар хичээлээ судлах нь ачаалал ихтэй байна гэж хариулсан байна.

Зураг 15. Хөтөлбөрийн оролцогч талуудтай харилцаа холбооны ямар сувгаар харилцаж байсан бэ?




Оюутнууд удирдагч багш болон ментортойгоо ихэвчлэн утсаар болон facebook mesanger-ээр холбогдож байсан нь албан ёсны харилцах суваг байхгүйтэй холбоотой байна. Судалгаанд хамрагдсан нийт оюутнууд буюу 100% бүтэн цагаар ажил хийгээд хажуугаар хичээлээ судлах нь ачаалал ихтэй байна гэж хариулсан байна.

Зураг 16. Оролцогч талуудыг холбосон нэгдсэн платформ байх шаардлагатай юу?



Зураг 17. Хөтөлбөрийн талаарх мэдээллийг анх хаанаас авсан бэ?



Оюутнуудын 15 нь буюу 88% нь оролцогч талуудыг холбосон платформ шаардлагатай гэж үзсэн нь харилцаа холбооны албан ёсны суваг байхгүй, ойлгомжгүй тодорхойгүй байдал их байдагтай холбоотой харагдаж байна. (Зураг 16)

Дийлэнх буюу 41% нь сургалтын албанаас, 35% нь цахим сувгаар, 18% нь найз нөхдөөсөө мэдээллийг авч байсан байна. (Зураг 17)

Зураг 18. Тус хөтөлбөрийг сонгосон шалтгаан?




Зураг 19. АБССХ-ийн дадлагажих 6 сарын хугацаа хэр тохиромжтой байсан бэ?



50% нь ажлын байран дээрээс шаардлагатай ур чадварыг эзэмших зорилгоор тус хөтөлбөрийг сонгосон байна. (Зураг 18)


59% нь АБССХ-ийн ажлын байран дээр дадлагажиж буй 6 сарын хугацааг тохиромжтой гэж үзсэн байна. (Зураг 19)

Зураг 20. Ажилласан байгууллагын юу нь таалагдсан бэ?



Байгууллагын соёл, хамт олны уур амьсгал, сурч хөгжих боломж болон өсөн дэвших боломжтой байгаа нь оюутнуудад таалагдсан байна.

Зураг 21. Ажилласан байгууллагын юу нь таалагдаагүй вэ?




Харин тухайн ажлын байранд цалин бага байгаа нь тухайн байгууллагад цаашид ажиллахгүй байх гол шалтгаан нь болж байна.

Оюутнуудын авч байсан цалингийн дээд хэмжээ нь 850 мянган төгрөг ба 76% нь 650 мянган төгрөгнөөс доош цалинтай байна. Энэ нь оюутнуудын 70% нь авч байсан цалингийн хэмжээнд сэтгэл хангалуун биш байхад нөлөөлсөн байна. (Зураг 22)

Оюутнуудын үзэж буйгаар цалингийн хэмжээ 900 мянган төгрөгнөөс 1 сая төгрөгийн хооронд тохиромжтой гэж үзэж байна. (Зураг 23)

Зураг 22. Цалингийн хэмжээ



Зураг 23. Тохиромжтой хэмжээ



Судалгаанд хамрагдсан оюутнуудаас АБССХөтөлбөрийн давуу болон сул тал мөн сайжруулах саналын талаар нээлттэй асуултын хариултыг дараах байдлаар нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 11. Хөтөлбөрийн талаарх нээлттэй асуулга.

Хөтөлбөрийн давуу тал	Хөтөлбөрийн сул тал	Сайжруулах санал
Бодит туршлага хуримтлуулах	Ачаалал ихтэй	Мэдээллээр сайн хангах
Ажлын байранд шаардлагта ур чадваруудыг эзэмших	Дадлагын тайлангийн үнэлгээ тодорхойгүй	Оролцогч талуудын уялдаа холбоо сайн байх
Онолын олон практикийн мэдлэгийн ялгаг ойлгох	Зохион байгуулалт муутай	Дүйцүүлэх хичээлийн тоог өсгөх.
Цалинтай	Харилцаа холбоо муу	Цалингийн хэмжээг өсгөх
Ажлын байраар хангагдах	Тулгарч буй асуудалд нь анхаарал хандуулдаггүй	Үнэлгээг ил тод, ойлгомжтой байлгах
	Хүссэн ажлын байран дээрээ ажиллаж чадахгүй байх	
	Үндсэн ажилчидтай ижил ачаалалтай ажилладаг ч цалингийн хэмжээ бага	

4.1.2 Удирдагч багшаас авсан судалгаа

АБССХөтөлбөрт хамрагдаж буй оюутнуудыг удирдан чиглүүлэх нийт 5 удирдагч багш байгаагаас 4 нь буюу 80% нь судалгаанд хамрагдсан.


Зураг 24. Удирдагч багш болохоос өмнө хөтөлбөрийн талаар хэр мэдээлэлтэй байсан бэ?



Хөтөлбөр эхлэхэд удирдагч багш нар хөтөлбөрийн талаар хангалттай сайн мэдээлэлгүй байсан байна.


Судалгаанд оролцогчдоос удирдагч багш болохоос өмнө АБССХ-ийн талаар ойлголт мэдээлэлийг түвшин хэр зэрэг болохыг судлахад 75% нь дунд зэрэг, 25% нь сайн ойлголт мэдээлэлтэй байсан.

Зураг 25. Одоо сургуулийн зүгээс хөтөлбөртэй холбоотой мэдээ мэдээллээр хэр хангаж байна вэ?




Харин одоо сургуулийн зүгээс хөтөлбөртэй холбоотой мэдээ мэдээллээр хэрхэн ямар түвшинд хангаж буй талаар тодруулахад нийт оролцогчдын 75% нь сайн, 25% нь дунд зэрэг гэж хариулсан байна.

Зураг 26. Дадлагын ментортой харилцахдаа ашиглаж буй харилцаа холбооны суваг



Дадлагын ментортой харилцахдаа харилцаа холбооны ямар сувгуудыг ашиглаж буй, харилцаанд асуудал гарч байгаа талаар судлахад нийт оролцогчид бүгд утсан харилцаа болон интернет харилцааг хослуулан харилцдаг байна.


Зураг 27. Дадлагажигч оюутантай харилцаа холбооны ямар сувгаар холбогдож байна вэ?



Харин судалгаанд оролцогчдоос оюутнуудтай харилцахдаа харилцаа холбооны ямар сувгыг ашиглаж буй талаар тодруулахад биечлэн уулзалтын харилцааг ашигладаггүй утсан болон интернет харилцааг хослуулан харилцдаг байна. Энэ нь тус хөтөлбөр нь зайнаас хамтран ажиллах ойлголцох боломжтойг харуулж байна.


Мөн багш нар байгуулагын ментортой харилцахад ямар нэгэн хүндрэл бэрхшээл байхгүй байгаа нь харагдаж байна.

Зураг 28. Хөтөлбөр эхэлснээс хойш оролцогч талуудтай хэдэн удаа холбогдсон бэ?



Ментортой огт холбогдоогүй тохиолдол харагдаж байгаа бол оюутантай харьцангуй холбогдож байсан нь харагдаж байна. 75% буюу 3 нь хөтөлбөрийн хугацаанд оролцогч талуудтай 1-3 удаа холбогдсон байгаа нь хөтөлбөрийн уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Зураг 29. Хөтөлбөрт удирдагч багшаар ажилласнаар таны ачаалал хэр нэмэгдсэн бэ?



Удирдагч багш нарын ачаалал хөтөлбөрийн талаарх мэдээлэл болон оролцогч талуудтай уялдаа холбоотой ажиллаж байгаагаас шалтгаалан харилцан адилгүй байна.

Зураг 30. Хөтөлбөр хэрэгжиж байгаа хугацааг тохиромжтой гэж үзэж байна уу?




50% нь буюу 2 нь хөтөлбөрийн хэрэгжиж буй хугацааг тохиромжтой гэж үзсэн.

Харин хугацааг их болон бага гэж хариулсан 2 оролцогчийн нэг нь хөтөлбөр хэрэгжих тохиромжтой хугацааг 4-6 долоо хоног гэсэн бол нөгөөх нь 6 сар гэсэн байсан нь хөтөлбөрийн талаарх мэдээлэл ойлголт муу багааг харуулж байна.

Харин удирдагч багш нар хөтөлбөрийн хэрэгжилт болон үр дүнтэй байдал бүгд 100% үр дүнтэй байна гэж хариулсан.

Зураг 31. Танилцах болон мэргэжлийн дадлагатай харьцуулахад АБССХ-ийн оюутанд бий болгож буй давуу талыг үнэлнэ үү. /5 Их, 4 Дунд, 3 Бага/



Дээрх графикаас харахад оролцогч талуудын уялдаа холбоо муу байгаа нь харагдаж байна.

Өрсөлдөх чадвар, шинэ оюутан татах элсэлтэнд давуу талыг бий болгож чадах эсэх дээр 100% чадна гэж хариулсан байсан ба үүнээс харахад хөтөлбөрийг цаашид хэрэгжүүлэх шаардлагатай харагдаж байна.

АБССХ-ийн давуу болон сул тал, сайжруулах санал зэргийг удирдагч багш нараас нээлттэй асууж дараах хүснэгтэнд нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 12. Удирдагч багш нараас авсан нээлттэй асуулгын хариулт

Давуу тал	Сул тал	Сайжруулах санал
Суралцах явцдаа ажлын байранд дадлагажиж, төгсөхөд ажлын туршлага, мэдлэгтэй болж ажиллах боломжтой болох.	Зарим хичээл орхигдох талтай	Тайлан хамгаалалтанд дүйцүүлэх хичээлийн агуулгыг бүрэн хамруулахгүй байх.
Гол нь практик чадвар олгож байгаа нь давуу тал гэж үзэж байна.	Банкны НББ хичээлийг үзэж амжаагүй оюутнуудаас хичээлийн дагуу шалгалт авах нь байж болохгүй гэж үзэж байна.	Зөвхөн 4-р курсын оюутныг хамруулах
Онол практик хосолсон.	Онолын мэдлэг хангалттай авч чадахгүй байх.	
	Мэргэжлийн хичээлийг дүйцүүлж байгаа нь академик мэдлэг хангалттай авч чадахгүй байх талтай.	

4.1.3 Сургуулийн зохицуулагчаас авсан асуулга, хариулт

Сургуулийн зохицуулагч нь АБСС-ын зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажилтан. Сургуулийн хэмжээнд 1 зохицуулагч байгаа ба зохицуулагчаас биечлэн уулзаж асуулга авсныг доорх хүснэгтэнд нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 13. Зохицуулагчаас авсан асуулга, хариулт

№	Асуулт	Хариулт
1	Зохицуулагчаар ажиллахаас өмнө та АБССХ-ийн талаар хэр мэдээлэлтэй байсан бэ?	Мэдээлэлтэй байсан. МВА судалгааны ажлын сэдэв нь “Ажлын байранд суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам” сэдвээр бичиж байсан.
2	Хөтөлбөрийн баримт бичиг, төлөвлөгөө хэр ойлгомжтой байсан бэ?	Бага зэрэг ойлгомжгүй байсан. Европ болон Монгол улсын боловсролын систем, хууль эрх зүйн орчин ялгаатай байсан учир шууд хөтөлбөрийн баримт бичиг боловсруулахад төвөгтэй санагдсан. Мөн өмнө нь хэрэгжиж байсан туршлага байхгүй байсан учир төлөвлөгөө ойлгомжгүй байсан.
3	Бусад оролцогч талуудтай харилцааны ямар сувгаар хамтран ажиллаж байсан бэ?	Мэйл харилцаа, утас гэх мэт хэрэгсэлийг ашигласан.
4	Бусад талуудтай харилцаж байгаа тайлангаа ямар төрлийн файл дээр нэгтгэж байсан бэ?	Сургуулийн зохицуулагч талууд дундаа drive үүсгээд хэрэгтэй файлуудаа хадгалаж байсан. Гэхдээ банктэй харилцаа тогтооход бага зэрэг төвөгтэй байсан. Учир нь мэдээллийн аюулгүй байдал зэрэг асуудлууд ихээхэн гардаг тул заавал зөвшөөрөл авч, мэйлээр мэдээллээ илгээдэг байсан.
5	Сургуулийн зүгээс нэгдсэн платформ цаашид хэрэгтэй юу таны бодлоор?	Хэрэгтэй гэж бодож байна.
6	Оюутнуудын зүгээс таньд санал гомдол гаргаж байсан уу? Тийм бол та дэлгэрэнгүй бичнэ үү. Хэрхэн хүлээн авч шийдвэрлэсэн бэ?	Байсан. Хөтөлбөрийн оюутнууд хичээл зохицуулалттай холбоотой асуудал их гарсан. Мөн банк бүрийн соёлын онцлогоос хамаарч Төрийн банкинд дадлага хийсэн оюутнууд ажлын байранд сэтгэл ханамжгүй байгаа тухай гомдол гаргасан.
7	Хөтөлбөртэй холбоотой үүсэж буй асуудлууд юу байна вэ?	Хөтөлбөртэй холбоотой хичээл зохицуулалт нь эхний ээлжинд ойлгомжгүй байсан. Сургалтын албаруу хүсэлт гаргах процесс нь төвөгтэй. Тусдаа зохицуулагч албан тушаалд хүний нөөц хэрэгтэй юм шиг санагдсан.
8	Байгууллагын зохицуулагч талуудаас ямар санал гомдол ирж байсан бэ? Хэрхэн хүлээн авч шийдвэрлэсэн бэ?	Одоогоор ирээгүй байгаа

9	2 ээлжийн хөтөлбөрт та хэрхэн үнэлгээ өгөх вэ?	10-8
10	Сургуулийн удирдлагын зүгээс цаашид хөтөлбөрийг дэмжиж оролцоход юу санаачлах шаардлагатай вэ?	Хөтөлбөрт зориулсан тусдаа сэдэвчилсэн төлөвлөгөө гаргах хэрэгтэй гэж бодож байна.
11	Хөтөлбөрт ажиллах нь таны үндсэн ажилд хэр их ачаалал нэмж байна бэ?	Шинэ модуль эхлэх үед ачаалал нэмэгддэг. Мөн шинэ ээлжийн оюутнуудын хичээл зохицуулалттай холбоотой маш их ачаалал үүсдэг. Оюутан тус бүрээр зохицуулалт хийгддэг учир, мөн хөтөлбөрт зөвхөн 4-р курсын оюутнуудыг хамруулах нь зөв гэж үзэж байна.
12	Нэмэгдэл цалин, урамшуулал авч байсан уу?	Байсан.
13	Хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд анхаарах зүйлс юу байна вэ?	Зөвхөн 4-р курсын оюутнуудыг хамруулах нь зөв гэж үзэж байна. Мөн банкны ангийн оюутнуудыг хамруулах
14	Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа тохиромжтой байна уу?	Үгүй. Хаврын семестер тохиромжтой гэж үзэж байна.
15	Оюутнуудтай та хэдэн удаа уулзалт хийсэн бэ?	4-с дээш удаа
16	Хөтөлбөрийн давуу тал нь юу вэ?	Оюутанд маш их боломж олгож байгаа. Сургуулийн зүгээс суралцах боломжгүй практик мэдлэг ур чадварыг авч байгаа
17	Хөтөлбөрийн сул тал нь юу вэ?	Зарим мэргэжлийн хичээлийг үзэхгүй байгаа нь бага зэрэг харамсалтай санагддаг.

4.2 Олон улсын карьерийн үйлчилгээг хэрэгжүүлж буй тэргүүн туршлага

Олон улсын их сургуулиудын эрэмбийн шалгуурт тухайн сургуулийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь нөлөөлдөг тул сүүлийн жилүүдэд их дээд сургуулиуд оюутнуудынхаа болон төгсөгчдийнхөө ажил эрхлэлтэд ихээр анхаардаг болсон. Үүний хүрээнд өөрийн гэсэн карьер хөгжлийн хэлтэс нэгжтэй болж төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулж байна. нийгэм, технологийн нөлөөнөөс зарим сургуулиуд өөрийн гэсэн карьер үйлчилгээний платформыг хөгжүүлэн ашиглах болсон. Их дээд сургуулийн карьер үйлчилгээний сайтуудын бүтцийг судлав.

Хүснэгт 14. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшингээр олон улсын их сургуулиудын эрэмбэ

Эрэмбэ	Их Сургууль	Үнэлгээ	Улс
#1	Массачусетсын Технологийн Институт Massachusetts Institute of Technology MIT	100	АНУ
#4	Сиднэйн Их Сургууль The University of Sydney	98.1	Австрали
#6	Цингхуа Их Сургууль Tsinghua University	96.9	Хятад
#7	Оксфордын Их Сургууль University of Oxford	96.7	Англи
#25	Токиогийн Их Сургууль University of Tokyo	87.8	Япон

Эх сурвалж: (ELSEVIER, 2023)

Олон улсын их сургуулиудын эрэмбийг төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшингээр харахад 100 оноогоор Массачусетсын Технологийн Институт, 98.1 оноогоор Сиднэйн Их Сургууль, 96.9 оноогоор Цингхуа Их Сургууль, 96.7 оноогоор Оксфордын Их Сургууль, 87.8 оноогоор Токиогийн Их Сургуулиуд 1,4,6,7 болон 25-р байруудад тус тус эрэмбэлэгдсэн байна.

Дээр дурдагдсан таван улсын таван их сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээллийг хүснэгт 2-6-д сургууль тус бүрээр дэлгэрэнгүй оруулав.

Хүснэгт 15. Массачусетсын Технологийн Институтын карьер үйлчилгээний сайтын мэдээлэл

Сургуулийн нэр	Массачусетсын Технологийн Институт (АНУ)
Линк	https://capd.mit.edu/ https://alum.mit.edu/careers
Нэр	Career Advising & Professional Development MIT ALUMNI
Үндсэн цэс	Карьерын арга хэмжээ ба Карьерын хөтөлбөр <ul style="list-style-type: none"> - MIT төгсөгчдийн карьерын нөхөрлөл (fellowship) - Ажлын байрны өдөрлөг - Карьерын видео Карьерын сурталчилгаа ба Нэтворкинг <ul style="list-style-type: none"> - MIT Alumni Advisors Hub (төгсөгчдийн) Ажлын байр https://capd.mit.edu/channels/employer/ (Ажил олгогчдод зориулсан вэбтэй)

	<ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтын календарь - Хамтран ажиллах - Ажил олгогчдын мөрдөх сонгон шалгаруулалтын журам - Өдөрлөг арга хэмжээний календарь - Ярилцлага товлох <p>Карьерын мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын зарын хайлтын сайтууд - Карьерын номнуудын жагсаалт - Ажлын байрны мэдээллийн сайт ONET - Карьер хөгжлийн төлөвлөгөө - Ур чадварын жагсаалт - MIT CAPD ажлын байрны өдөрлөг - Төгсөгчдийн зөвлөгөө <p>Ажил олгогч</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын зар мэдээлэл байршуулах талбар Alum.mit.edu/hire
--	--

Эх сурвалж: (Massachusetts Institute of Technology, 2023)

Массачусетсын Технологийн Институтын карьер үйлчилгээний сайт нь 5 үндсэн цэстэй бөгөөд төгсөгчдийн холбоо, төгсөгчдийн оролцоо ихтэй болох нь хэд хэдэн цэсүүдээс харагдаж байна.

Хүснэгт 16. Сиднейн Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл

Утга	Сиднейн Их Сургууль (Австрали)
Линк	https://www.sydney.edu.au/about-us/careers-at-sydney.html
Нэр	Careers at Sydney
Үндсэн цэс	<p>Академик ажлын байр</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээлэл - Ажилтнуудын танилцуулга - Ажлын зар хайх - Холбоо барих <p>Мэргэжлийн ажлын байр</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээлэл - Ажилтнуудын танилцуулга - Ажлын зар хайх - Холбоо барих <p>Уугуул иргэдийн ажлын байр</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээлэл - Ажилтнуудын танилцуулга - Ажлын зар хайх - Холбоо барих - Уугуул иргэдийн ажил эрхлэлтийн статистик мэдээлэл - Уугуул иргэдийн ажиллах хүчний стратеги төлөвлөгөө <p>Тусгай хэрэгцээт хүнд зориулсан ажлын байр</p> <ul style="list-style-type: none"> - Тайлбар - Ажилтнуудын танилцуулга - Ажлын зар хайх - Холбоо барих - Тусгай хэрэгцээт хүний оролцоог дэмжих төлөвлөгөө <p>Сонгон шалгаруулалтын процесс</p> <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтын үе шат

	<ul style="list-style-type: none"> - CV бичих заавар - Ярилцлаганд бэлдэх заавар - Нийтлэг асуугддаг асуултууд - Тусгай хэрэгцээт хүний сонгон шалгаруулалтанд туслах хэсэг - Холбоо барих - Бүрдүүлэх бичиг баримтын маягтууд татах боломжтойгоор байрлуулсан <p>Ажилтны хөнгөлөлт, хангамж</p> <ul style="list-style-type: none"> - Уян хатан нөхцөл - Гэр бүлд зориулсан - Санхүүгийн дэмжлэг - Карьерын боломж - Эрүүл мэнд, сайн сайхан - Тээврийн хэрэгсэл - Соёл <p>Хороо, нийгэмлэг</p> <p>Ажлын байрны зар цэс</p> <ul style="list-style-type: none"> - Нэвтрэх хэсэг - Хайлтын хэсэг - Филтер хэсэг - Байршил - Бүтэн цаг/Хагас цаг - Ажлын байрны ангилал - Ажлын байрны төрөл
--	---

Эх сурвалж: (The University of Sydney, 2023)

Сиднейн Их Сургуулийн карьер үйлчилгээний сайт нь 8 үндсэн цэстэй бөгөөд тухайн улсын цөөнх болоод байгаа уугуул иргэд, өв соёлоо дэмжих зорилгоор уугуул иргэдийн карьер хөгжлыг анхаардаг болох нь бусдаас ялгаатай онцлог байна. Мөн ажлын байрны зарын хэсэг нь маш ойлгомжтой байна.

Хүснэгт 17. Оксфордын Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл

Утга	Оксфордын Их Сургууль
Линк	https://www.careers.ox.ac.uk/
Нэр	Career Service
Үндсэн цэс	<p>Карьерын тухай</p> <ul style="list-style-type: none"> - Карьерын өдөрлөг - Карьер хөгжлийн тухай - Карьер шилжилт - Салбар, ажлын байрны тухай <p>Ажлын зарын хайлт</p> <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтын хэрэгслүүд - Ажлын санал хүлээн авах, хариу үзүүлэх - Ярилцлага - Ажлын зар хайх - Сэтгэл зүйн тест - Анкет бичих заавар <p>Ур чадвараа хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хувийн хөгжлийн сургалтууд - Цахим сургалт - Удирдах түвшний сургалт

	Дадлага <ul style="list-style-type: none"> - Зуны дадлагын хөтөлбөр - Менторын хөтөлбөр - Микро дадлагын хөтөлбөр - Туршлага судлах дадлага Судалгаа Тэгш байдал <ul style="list-style-type: none"> - Олон талт оролцоог хангах - Тусгай хэрэгцээт хүний карьер - Тэгш байдал Хэрхэн туслах Хэн туслах
--	---

Эх сурвалж: (Oxford University, 2023)

Оксфордын Их Сургуулийн карьер үйлчилгээний сайт нь 8 үндсэн цэстэй бөгөөд карьер хөгжил, хувь хүний хөгжлийн сургалтуудыг олноор байршуулсан нь бусдаас ялгаралтай харагдаж байна. Мөн сүүлийн үед трэнд болж буй нийгмийн хариуцлагын бодлогын хүрээнд оюутнуудын олон талт ялгаатай байдал оролцоог дэмжих, тусгай хэрэгцээт оюутны карьерын тухай оруулсан байна. (Oxford University, 2023)

Хүснэгт 18. Цингхуа Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл

Утга	Цингхуа Их Сургууль
Линк	https://www.careers.ox.ac.uk/
Нэр	Career Development
Үндсэн цэс	Карьер хөгжил <ul style="list-style-type: none"> - Ажлын байранд бэлтгэх сургалт Pre-Job Training - Ур чадвар дээшлүүлэх хөтөлбөр Нээлттэй ажлын байрны зар ШУ-ны академын гишүүд Инженерчиллийн академийн гишүүд Төгсөгчид <ul style="list-style-type: none"> - Төгсөгчдийн холбоо - Төгсөгчдийн арга хэмжээ - Төгсөгчдийн түүх - Төгсөгчдийн шагнал

Эх сурвалж: (Tsinghua University, 2023)

Цингхуа Их Сургуулийн карьер үйлчилгээний сайт нь 5 үндсэн цэстэй бөгөөд дэд цэс багатай цомхон байсан. Бусдаас онцлог зүйл нь шинжлэх ухаан, инженерчиллийн академийн гишүүдийн мэдээлэл дэлгэрэнгүй байгаа нь өөрийн чадварлаг боловсон хүчинтэй гэдгээ харуул байж болох юм.

Хүснэгт 19. Токиогийн Их Сургуулийн карьер үйлчилгээний сайтын мэдээлэл

Утга	Токиогийн Их Сургууль (Япон)
Линк	https://www.u-tokyo.ac.jp/en/about/jobs.html
Нэр	Jobs
Үндсэн цэс	<p>Токиогийн их сургуулийн тухай</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байрны мэдээлэл - Нээлттэй ажлын байрны жагсаалт - Анкетны загвар татан авах - Анкет бөглөх заавар жишээ - Төгсөгчдийн статистик мэдээлэл <p>Хөтөлбөрүүд</p> <ul style="list-style-type: none"> - Тэнхимүүд - Салбар сургуулиуд - Судалгаа шинжилгээ - Олон улсын хөтөлбөрүүд - Боловсролын арга хэмжээнүүд <p>Яагаад Токиогийн их сургууль гэж?</p> <ul style="list-style-type: none"> - Сургуулийн кэмпус - Оюутнуудын танилцуулга - Багш нарын танилцуулга U Tokyo Voice - Токио хотын тухай - Японы тухай <p>Судалгаа шинжилгээ</p> <ul style="list-style-type: none"> - U Tokyo Focus - Судалгааны хамтын ажиллагаа - Судалгааны арга хэмжээнүүд <p>Төгсөгчид</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээ мэдээллүүд - Төгсөгчдийн холбоо - Холбоо (онлайн нийгэмлэг, имэйл сэтгүүл) - Сурах - Оюутнуудаа дэмжих (арга хэмжээ, гадаадад суралцах нь семинар, ажлын байрны ярилцлага туршилт, ажил эрхлэлтийн семинар, шинэ оюутнуудаа хүлээн авах арга хэмжээ, дунд сургуулийн сурагчдад зориулсан нээлттэй өдрүүд, тэтгэлэг) - Ивээн тэтгэлэг - Төгсөгчдийн нийгэмлэгийн цахим сэтгүүл <p>Оюутнуудын ирээдүй</p> <p>Оюутнууд</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээ мэдээллүүд - Виз - Орон байр - Эрүүл мэнд - Төлбөр, тэтгэлэг - Карьерын дэмжлэг - Япон хэл сурах - Кэмпус доторх үйлчилгээнүүд - Солилооны хөтөлбөрүүд - Дүрэм журам - Сургуулийн жилийн календарь - Арга хэмжээнүүд

Эх сурвалж: (The University Of Tokyo, 2023)

Токиогийн Их Сургуулийн карьер үйлчилгээний сайт нь 7 үндсэн цэстэй бөгөөд оюутны суралцах орчин нөхцлийн тухай мэдээлэл ихтэй байсан нь оюутнууд шаардлагатай мэдээллүүдийг сайн өгдөг харагдаж байна. (The University Of Tokyo, 2023)

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин дээгүүр эрэмбэлэгддэг дээрх таван сургуулиудын карьер үйлчилгээний сайтын бүтцийн хувьд нэгтгэн Хүснэгт 7-д харуулав. Их сургуулиудын карьер үйлчилгээний сайтуудыг судлан харахад Үндсэн цэс буюу Сургуулийн танилцуулга, Арга хэмжээний календарь, Карьер үйлчилгээний цэс буюу Карьерын зөвлөгөө, Ажлын байрны зар, Сургалт гэсэн цэснүүд заавал байх хэрэгтэй харагдаж байна.

Хүснэгт 20. Харьцуулсан матриц

Цэс		Массачусетс ын Технологийн Институт	Оксфорд ын Их Сургууль	Сидней Их Сургууль	Токиогийн Их Сургууль	Цингхуа Их Сургууль
Сургуулийн танилцуулга	Үндсэн цэс	+	+	+	+	+
Арга хэмжээний календарь		+	+	+	+	+
Карьерын зөвлөгөө	Карьерын үйлчилгээний цэс	+	+	+	+	
Ажлын байрны зар		+	+	+	+	+
Сургалт				+		

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Сургуулийн танилцуулга хэсэгт сургуулийн түүхэн замнал, сургалтын хөтөлбөр зэргээс гадна манай сургуульд сурснаар хувь хүнд бий болох давуу талуудыг онцлон тусгасан байна. Арга хэмжээний календарь цэсэнд сургуулийн хичээлийн жилийн хуваарь, дотоод үйл ажиллагааны хуваарь, төгсөлтийн хуваарь зэргээс гадна ажлын байрны өдөрлөг, карьер үйлчилгээний өдөрлөгүүдийн хуваарийг календарьчилсан хэлбэрээр оруулсан байна. Карьерын үйлчилгээний сайтын чухал цэсүүд болох Карьерын зөвлөгөө, Ажлын байрны зар болон Сургалт цэснүүдээр дамжуулан оюутан, төгсөгчдөө ажлын байранд бэлтгэж, ажил олгогчидтой холбож өгч байна. Карьерын зөвлөгөө цэсэнд ажлын байрны сонголт хийхээс эхлээд ажлын байранд хэрхэн амжилттай ажиллах талаарх зөвлөгөөнүүдийг хамруулсан бол Сургалт цэсэнд ажлын байрны сонголт хийхэд өөрийгөө танин мэдэх шинжтэй сургалт зөвлөгөө болоод ажлын байранд шаардлагатай байгаа ур чадваруудад өөрийгөө бэлтгэх сургалт зөвлөгөөг багтаасан байна.

4.3 СЭЗИС-д Карьер үйлчилгээ болон АБССХ-ийг сайжруулах арга зам

4.3.1 АБССХ

АБССХ-ийг хэрэгжүүлж байгаа Азийн бүс нутгийн улс орнуудын туршлагаас харахад Европын улсуудын сайн туршлагыг Erasmus, GIZ / Германы хамтын ажиллагааны нийгэмлэг/, UNDP /НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр/, ILO /Олон улсын хөдөлмөрийн байгууллага/, World Bank /Дэлхийн банк/ гэх мэт хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлсэн байна. Манай улсын хувьд анхны төсөл нь амжилттай хэрэгжээд явж байгаа нь сайн талтай. Хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад дараах хүндрэл бэрхшээлүүд тулгарч болзошгүй байна.

- ✓ Эрх зүйн орчны хувьд оюутны ажил эрхлэлтийг зохицуулах эрх зүйн орчин тодорхойгүй
- ✓ Хос хөтөлбөртэй ахлах сургууль хомс
- ✓ Мэргэжлийн дадлагын хуульгүй

Тиймээс Засгийн газар талаас хууль зүйн орчинтой болох ИДС-ын боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоонд АБССХ-ийг оруулж өгөх шаардлагатай байна.

ИДС-ын талуудаас сургалтын албанд дадлагын асуудал төвүүдийг байгуулан өөрсдийн сургуулиудын платформдоо оруулан мэдээллээр хангаж оюутнуудыг АБССХ-т хамруулах давуу талтай.

Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнгээс харахад оролцогч талуудад тулгарч буй хүндрэл, асуудлуудыг харахад оюутанд тулгарч буй асуудал их байна. Нийтлэг харагдаж буй асуудал нь оролцогч талуудын уялдаа холбоогүй байдал болон тодорхойгүй байдал ихтэй, мэдээ мэдээлэл хангалтгүй байгаа нь харагдаж байна. Эдгээрээс дараах сайжруулах саналыг гаргаж ирсэн.

1. Дадлагын тайланд дүйцүүлэх хичээлийн агуулгыг бүрэн хамруулахгүй байх
2. Санхүүгийн хөтөлбөрийн оюутан болон 3-р курсын оюутнуудын хичээл зохицуулалтыг сайжруулах
3. Хөтөлбөрт зориулсан тусдаа сэдэвчилсэн төлөвлөгөө гаргах
4. Оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах, мэдээ мэдээллээр хангах
5. Үнэлгээг ил тод ойлгомжтой байлгах

Цаашид АБССХ-т хамрагдах оюутны тоо болон хамтран ажиллах байгууллагын тоо нэмэгдэх тул оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулахын тулд тэдгээрийг холбосон платформ хөгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

4.3.2 Карьер үйлчилгээ

СЭЗИС-ийн карьер үйлчилгээг олон улсын их дээд сургуулиудын карьер үйлчилгээтэй харьцуулан хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 21. ОУ-н их сургуулиудын карьер үйлчилгээний сайтын бүтэц ба СЭЗИС өнөөгийн байдал

Утга	Олон улсын их сургуулиудын карьер үйлчилгээний сайт	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
Сургуулийн танилцуулга	+	+
Арга хэмжээний календарь	+	Googlesheet
Карьерын зөвлөгөө	+	Хөгжлийн семинар
Ажлын байрны зар	+	infosys.edu.mn ufe_connected_ufe.edu.mn сургуулийн фэйсбүүк хуудас
Сургалт	+	Бизнесийн харилцаа хичээлийн семинар

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Сургуулийн карьерын үйлчилгээг олон улсын их сургуулиудын үзүүлдэг карьерын үйлчилгээнүүдтэй харьцуулан харахад агуулгын хувьд бүхийл үйлчилгээг оюутнууддаа хүргэхийг зорин ажилладаг болох нь харагдаж байна. Сургуулийн танилцуулгыг вебсайтаар, арга хэмжээний календарийг googlesheet-ээр, карьерын зөвлөгөөг хөгжлийн семинар, ажлын байрны зарыг имэйлээр, сургалтуудыг хөгжлийн семинар хэлбэрээр тус тус хүргэж байна.

Дээрх хүснэгтээс харахад сургууль оюутнуудынхаа карьерын хөгжилд анхаарч олон төрлийн ажлуудыг олон хэлбэрээр, олон талуудыг хамруулан хийж байна. Гэсэн хэдийч оюутан дээрх бүх үйлчилгээг нэг цэгээс авч чадахгүй байгаагаас шалтгаалан мэдээллээс хоцрох, мэдээлэл цагтаа хүрэхгүй байх зэрэг байдлууд гарч байна. Мөн сургалтын албаны зүгээс оюутны хөдөлмөр эрхлэлтийн тайлан, сайн дурын ажлын тайлан зэрэг тайлан мэдээ гаргахад цаг хугацаа их зарцуулдаг байна. Тиймээс АБССХ-н оролцогч талуудыг холбосон платформ дээр карьер үйлчилгээний цэсийг нэмж хөгжүүлэх боломжтой гэж үзэн, дараах санал зөвлөмжүүдийг дэвшүүлэн Хүснэгт 22-д тусгав.

Хүснэгт 22. Карьер үйлчилгээний хөгжүүлэх санал


Цэс	Дэлгэрэнгүй
Ажлын байрны зар	Ажил олгогчидтой хамтын ажиллагааны гэрээ байгуулан платформд эрхийг нээн өгч, дараах сонголтуудыг нэмэх <ul style="list-style-type: none"> - Бүтэн цагийн ажил - Хагас цагийн ажил
Карьерын зөвлөгөө	Ажил олгогчидтой байгуулах хамтын ажиллагааны гэрээний хүрээнд дараах арга хэмжээнүүдэд дэмжлэгтэй оролцох талаар заах <ul style="list-style-type: none"> - Зөвлөгөө – Подкаст, Видео, Нийтлэл - Тодорхойлсон ажлын байруудад танилцах тур хийх - Биечилсэн уузалт, лекц
Сургалт	- Ерөнхий ур чадварын олон мэргэжлийн ур чадварын сургалтуудыг бэлтгэн цахим талбарт байршуулах

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

4.4 Карьер үйлчилгээний платформын шаардлага

Олон улсын шилдэг их дээд сургуулиудын АБСС, карьер үйлчилгээтэй холбоотой цахим хуудас, платформыг харьцуулан судалсан судалгааны үр дүн болон оролцогч талуудад тулгамдаж буй асуудал дээр тулгуурлан платформын шаардлагыг дараах байдлаар гаргасан.

Зураг 32. АБСС Платформын шаардлага



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Шаардлага (Оюутан)

Оюутан нь сургуулийн Инфосис систем дээрх өөрсдийн эрхээр тус платформруу нэвтрэх ба АБСС-ын зар харах, нийт явцын төлөв харах, тухайн дадлагажсан байгууллагад үнэлгээ өгөх гэсэн үндсэн шаардлагатай. Дээрх зураглалд зөвхөн АБССХ-ийн шаардлагыг гаргасан ба доорх дэлгэрэнгүй шаардлагад ажлын байрны төрлийг дадлага, сайн дурын ажил, АБСС, хагас цагийн ажил, бүтэн цагийн ажил гэсэн сонголттой байхаар оруулсан.

Хүснэгт 23. Платформын шаардлага (Оюутан)

№	Шаардлагын товчлол	Шаардлагын дэлгэрэнгүй	
1	Ажлын зар харах	Тайлбар	Нээлттэй зарлагдсан ажлын байрыг харах.
		Талбар	<p>Сонгох</p> <ul style="list-style-type: none"> -Компани /Голомтбанк, Төрийн банк гэх мэт бүртгэлтэй компаниудаас сонгох/ -Мэргэжил - /Эрсдэлийн удирдлага, Бизнес хөгжил, Маркетинг/Борлуулалт гэх мэт/ <p>Чеклэх</p> <ul style="list-style-type: none"> -Ажлын байрны төрөл <ul style="list-style-type: none"> ✓ Дадлага ✓ Сайн дурын ажил ✓ АБСС ✓ Хагас цагийн ажил ✓ Бүтэн цагийн ажил гэсэн сонголтуудтай байна. <p>Шүүж харах товч Шинээр эхлэх товч</p> <p>Нийт нээлттэй ажлын байрны тоо</p> <ul style="list-style-type: none"> -Ажлын байр -Байгууллага -Мэргэжил -Огноо -Дэлгэрэнгүй харах товч
		Санамж	<ol style="list-style-type: none"> 1. Шүүлтүүрээр сонгосон ажлын байрууд ялгарч харагдах. 2. Тухайн ажлын байруудыг дэлгэрэнгүй харах товч дээр дарж дэлгэрэнгүй харна. Дэлгэрэнгүй харахын тулд оюутан өөрийн эрхээр нэвтэрч орсон байх шаардлагатай. 3. Нэвтэрч орсны дараа тухайн ажлын байрыг хадгалах болон анкет илгээх товч харагдана.
Хавсралт	<p>Хавсралт 5. Ажлын байрны зар ажлын байрны төрлүүдээр харагдах байдал.</p> <p>Ажлын байрны төрлүүдэд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Дадлага 2. Сайн дурын ажил 3. АБССХөтөлбөр 4. Хагас цагийн ажил 5. Бүтэн цагийн ажил 		
2	Анкет үүсгэх	Тайлбар	Өгөгдсөн загварын дагуу анкет үүсгэх
		Талбар	<p>Анкет үүсгэх товч</p> <p>Ерөнхий мэдээлэл</p> <ul style="list-style-type: none"> - Миний тухай -Эцэг/эх-ийн нэр -Өөрийн нэр

			-Регистрийн дугаар -Хүйс -Төрсөн огноо Холбоо барих мэдээлэл -Утасны дугаар -Имэйл хаяг -Оршин суугаа хаяг -Сошиал хаяг /Instagram, Facebook, LinkedIn/ Ажиллахаар төлөвлөж буй ажлын байр -Цалингийн хүлээлт -Ажиллах төрөл -Ажиллах чиглэл Боловсрол -Боловсролын зэрэг -Улс -Сургуулийн нэр -Эзэмшсэн мэргэжил -Голч дүн /GPA/ -Элссэн он -Төгссөн он /Одоо сурч байгаа бол одоо сурч байгааг чеклэх/ Гадаад хэл -Хэл -Түвшин Компьютерийн програм дээр ажиллах чадвар -Програм -Зэрэг түвшин Нэмэлт ур чадвар -Хувийн ур чадвар /Ур чадваруудаас сонгох/ -Урлагийн авьяас /Урлагийн нэр, цол түвшин/ -Спортын ур чадвар /Спортын нэр, Зэрэглэл/ Хавсаргах файл Оюутны тодорхойлолтууд -Дүнгийн тодорхойлолт -Ёс зүйн тодорхойлолт -Авьяас чадварын тодорхойлолт Хадгалах товч
		Санамж	1. Дээрх анкетын утгуудаас инфосис системээс татагдах боломжтой мэдээллүүд автоматаар татагдана. 2. Өөрийн оруулсан анкетын мэдээллийг засварлах боломжтой байх.
		Санал, зөвлөмж	Байгууллагуудын өөрсдийн шинэ ажилтан сонгон шалгаруулах журмаар буюу ажилд авах процессоор явагдаж байгаа тул томоохон байгууллагуудын ажлын зар авдаг системтэй интеграци хийх боломжтой байвал давуу талтай гэж харж байна.
3	Анкет илгээх	Тайлбар	Өөрийн үүсгэсэн анкетыг сонгосн ажлын байранд илгээх. Нээлттэй зарлагдсан байгаа ажлын байруудаас өөрийн сонгосон ажлын байрыг дэлгэрэнгүй харах товч дарж орсноор анкет илгээх товчин дээр дарж тухайн ажлын байран дээр анкетыг илгээнэ.
		Талбар	Байхгүй
4	Сургалт үзэх	Тайлбар	Оюутан хөгжлийн бодлогын 5.1-д зааснаар Ажлын байранд бэлтгэх сургалтуудыг байршуулах.

		Талбар	5 чиглэлийн цахим сургалтууд байна. 5.1 Ажлын байранд бэлтгэх сургалт 1. Албан харилцааны соёл 2. Карьер хөгжил 3. CV, товч намтар бичих 4. LinkedIn хэрэглээ 5. Ажлын байрны сонгон шалгаруулалтын ярилцлаганд бэлтгэх.
		Санамж	Тус сургалтуудыг Сургалт үзэх товч дарснаар Moodle системрүү үсрэх ба өөрийн эрхээр нэвтэрч орон сургалтуудыг үзнэ.
		Санал, зөвлөмж	Оюутан дээрх сургалтуудад сууснаараа оноо цуглуулах ба цуглуулсан оноо нь Moodle систем дээр харагдана. Тус оноог Moodle системтэй интеграц хийж харагдах боломжтой байлгаж болно.
5	Тодорхойлолт авах хүсэлт илгээх	Тайлбар	Зарим ажил олгогчид нэмэлт тодорхойлолт авахыг шаардаж болох ба тэдгээр нэмэлт тодорхойлолтууд нь дараах тодорхойлолтууд байна. 1. Дүнгийн тодорхойлолт - БМТ 2. Ёс зүйн зөрчлийн тодорхойлолт - БСА 3. Амжилтын тодорхойлолт - БСА
		Талбар	Өөрийн авах тодорхойлолтыг чеклэх. 1. Дүнгийн тодорхойлолт - БМТ 2. Ёс зүйн зөрчлийн тодорхойлолт - БСА 3. Амжилтын тодорхойлолт - БСА Илгээх товч.
		Санамж	Тус тодорхойлолтуудыг баталгаажуулах шийдлийг гаргах хэрэгтэй. Жишээ нь: QR кодоор баталгаажуулах.
6	Өргөдөлийн статус харах	Тайлбар	Өргөдөлийн явцыг үе шатаар нь харах.
		Талбар	Өргөдөлийн статус дараах үе шатуудаар харагдана. -Шийдвэр хүлээгдэж байна -Сонгон шалгаруулалт хийгдэж байна -Шийдвэр гарсан
		Санамж	Ирсэн мэдэгдэлүүд ерөнхий цэсний Миний зурвас цэсэнд харагдана.
		Санал, зөвлөмж	Статус солигдох бүрт оюутны бүртгэлтэй имэйл хаягаар мөн бүртгэлтэй утасны дугаараар мэдээлэл ирэх боломжтой.
7	АБССХ-ийн үнэлгээ харах	Тайлбар	Тус хөтөлбөрт хамрагдсан оюутнуудад ажил олгогч байгууллага нь дадлагын үнэлгээг оруулна. Нийт 6 сарын хугацаанд ажлын байранд дадлагажих ба 2 удаагийн дадлагын тайлан хамгаалалтын үнэлгээг оруулдаг.
		Талбар	Дадлагын тайлан хамгаалалтын үнэлгээ 1-р ээлжийн үнэлгээ, 2-р ээлжийн үнэлгээ
		Санамж	Энэ нь зөвхөн АБССХ-т хамааралтай.
8	Профайл харах	Тайлбар	Өөрийн профайлыг харах.
		Талбар	Профайл нь дараах үндсэн цэсүүдтэй байна. 1. Миний анкет 2. Хадгалсан ажлын зар 3. Миний түүх 4. Миний зурвас 5. Хувийн тохиргоо 6. Ажлын зар харах

			7. Хүсэлт явуулах
--	--	--	-------------------

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Шаардлага (Ажил олгогч)

Ажил олгогч буюу байгууллагын хувьд тус платформ нь (Зураг 32)-т харуулснаар АБСС-ийн зар оруулах, ирсэн анкетын хүсэлт болон анкет илгээсэн оюутнуудыг жагсаалтаар харах, хөтөлбөрт хамрагдсан оюутанд үнэлгээ өгөх, холбоотой тайлан мэдээг харах үндсэн шаардлагыг хангасан байна. Шаардлагын дэлгэрэнгүйд мөн оюутныхтай ижил ажлын байрны төрлийг дадлага, сайн дурын ажил, АБСС, хагас цагийн ажил, бүтэн цагийн ажил гэсэн сонголттой байхаар оруулсан.

Хүснэгт 24. Платформын шаардлага (Ажил олгогч)

№	Шаардлагын товчлол	Шаардлагын дэлгэрэнгүй	
1	Ажлын зар оруулах	Тайлбар	Ажлын зарын жагсаалт болон ажлын зар үүсгэх товч байрлах
		Талбар	Шинэ захиалга үүсгэх - Ажлын байрны нэр - (Гараас оруулах) - Байгууллагын нэр - (Гараас оруулах) - Гүйцэтгэх ажил үүрэг - (Гараас оруулах: max150 тэмдэгт байхаар текст оруулах) - Тавигдах шаардлага - (Гараас оруулах: Мэргэжлийн ур чадвар / Ерөнхий ур чадвар/ Тусгай ур чадвар) - Ажлын байрны төрөл - Сонгох Дадлага/ Сайн дурын ажил/ АБССХөтөлбөр/ Бүтэн цагийн ажил/ Хагас цагийн ажил - Цагийн хуваарь (Гараас оруулах) - Хугацаа (Гараас оруулах) - Цалин (Гараас оруулах) - Сул орон тоо (Гараас оруулах) - Сул орон тоо нөхөх сүүлийн огноо (Календариас сонгох) Захиалга үүсгэх (Захиалга үүсгэх товч дарсны дараа идэвхитэй жагсаалт руу шилжих бөгөөд тэнд Устгах, Засах, Зар хүсэлт илгээх, Хугацаа сунгах, Харах товчнууд байрлана)
		Санамж	Байгууллага зараа нийтлэхдээ мэргэжлээр шүүлт хийж нийтлэх боломжтой байх. Тухайн зарыг хэн харуулах вэ гэдгийг сонгож өгөх. Тус сонголтуудад: Бүгдийг сонгох, Оюутан, Төгсөгч гэсэн сонголтууд байна. Зар засах - Оруулсан зараа засах боломжтой байх Зар устгах - Тухайн зарын сонгон шалгаруулалт дууссан бол зарыг устгах эсвэл нуух боломжтой байх. Зар нэмэх - Шинэ зар нэмэх
Хавсралт	Хавсралт5. Ажлын байрны зар ажлын байрны төрлүүдээр харагдах байдал. Төрөл бүрээр шаардлагатай мэдээллүүдийг оруулан хадгалах товч дарна. Ажлын байрны төрлүүдэд: 1. Дадлага 2. Сайн дурын ажил 3. АБССХөтөлбөр 4. Хагас цагийн ажил 5. Бүтэн цагийн ажил		
2	Ирсэн анкетыг харах	Тайлбар	Ажлын зар бүрээр анкетын жагсаалтыг харах
		Талбар	Ажлын зарын жагсаалт

			<ul style="list-style-type: none"> - Ажлын байр, Сул орон тоо, Нөхсөн орон тоо, Дуусах огноо, Нээгдсэн огноо, Ирсэн анкет (анкетын тоо харагддаг байх) Анкетын жагсаалт - Ирсэн анкет дээр дарахад анкетуудын жагсаалт харагдана. Жагсаалт нь анкетын дугаар, Эцэг/Эхийн нэр, Өөрийн нэр, Регистрийн дугаар, Утас, Эцсийн шийдвэр гэсэн багануудтай байх. - Анкет (Зураг, Ерөнхий мэдээлэл, Холбоо барих мэдээлэл, Боловсрол, Ажлын туршлага, Нэмэлт ур чадвар) - Тэмдэглэл (Гараас оруулах: Шийдвэрийн тухай тэмдэглэл оруулах) - Шийдвэр (Сонголтот: Ажилд авах, Татгалзах, Нөөцөнд бүртгэх) Татаж авах Хэвлэх
		Санамж	<ul style="list-style-type: none"> Хэрвээ CV resume хавсрагдсан байвал түүнийг татаж авах боломжтой байх Дүнгийн тодорхойлолт авах хүсэлт илгээх товчтой байх Авьяас чадварын тодорхойлолт авах хүсэлт илгээх товчтой байх Ёс зүйн тодорхойлолт авах хүсэлт илгээх товчтой байх
3	Зурвас илгээх	Тайлбар	Тухайн сонгон шалгаруулалтын үе шат болон оюутанд илгээх мэдээлэл байвал зурвас илгээнэ.
		Талбар	<ul style="list-style-type: none"> Мэдэгдэл - Ирсэн мэдэгдлийн жагсаалт харагддаг байх Зурвас илгээх - Утасны дугаар - Зурвасын агуулга - Түүх
		Санал зөвлөмж	Хүсэлт гаргасан тодорхойлолтын үр дүн харагддаг байх.
4	Хувийн тохиргоо	Тайлбар	Нууц үг солих, хадгалах.
		Талбар	<ul style="list-style-type: none"> Хуучин нууц үг Шинэ нууц үг Шинэ нууц үгээ давтаж хийх
		Санамж	Тухайн ажил олгогчийн бүртгэлийг сургуулиас үүсгэх тул зөвхөн нууц үгээ солих боломжтой.

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Шаардлага (Сургууль)

Тус платформын үндсэн эзэмшигч сургууль байх ба АБСС-ын удирдагч багш томилох, АБСС бүртгэл нээх, байгууллагад эрх нээх, АБСС жагсаалт гаргах, АБСС төлөв тоо харах, АБСС тайлан харах гэсэн үндсэн шаардлагуудтай. Мөн заримт бүртгэл үүсгээгүй байгууллагаас ирсэн аливаа зарыг сургуулийн зүгээс оруулах бүрэн боломжтой байна.

Хүснэгт 25. Платформын шаардлага (Сургууль)

№	Шаардлагын товчлол	Шаардлагын дэлгэрэнгүй	
1	Хэрэглэгчийн жагсаалт харах	Тайлбар	Системд бүртгэлтэй хэрэглэгчийн бүртгэлийг хянах. Нэвтрэх нэр, нууц үгийг зөв оруулснаар програм хангамжийн үндсэн цонх доорх байдлаар гарч ирнэ. Хэрэглэгчийн мэдээллийг бүлэглэж харахдаа баганы нэр дээр дарахад групплэх командууд гарч ирэх болно.
		Талбар	-Нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо /Жагсаалт хэлжбэрээр хагадах; Оюутан, бакалавр, мастер, байгууллага/ -Нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо мэргэжлээр -Нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо хүйсээр -Нийт ажил олгогч байгууллагын тоо -Нийт шинээр нэмэгдсэн хэрэглэгчийн тоо огноогоор /Сүүлийн хоног, долоо хоног, сараар/
		Санамж	1. Үндсэн нүүр хуудсанд харагдана 2. Хэрэглэгчийн жагсаалт харах дээр дарахад бүх хэрэглэгчийн мэдээлэл харагдана. 3. Хэрэглэгчийн багана бүрт байрлах шүүлтүүрийн мөрөнд шүүх утгыг оруулж шүүнэ. Эсвэл олон утгаар шүүх бол утгаар шүүх багана дээрх шүүх товч дээр дарж утгуудыг сонгоно.
2	Ажлын байраар харах	Тайлбар	Үндсэн нүүр хуудсанд харагдана.
		Талбар	Идэвхитэй (Жагсаалт хэлбэрээр харагдах: Ажлын байр, Төлөв) -Сул орон тоо -Нөхсөн орон тоо -Сул орон тоо Нийт (Жагсаалт хэлбэрээр харагдах: Ажлын байр, нөхөгдөх огноо, Төлөв) -Сул орон тоо -Нөхсөн орон тоо -Сул орон тоо Дууссан (Жагсаалт хэлбэрээр харагдах: Ажлын байр, нөхөгдөх огноо, Төлөв) -Сул орон тоо -Нөхсөн орон тоо -Сул орон тоо Ажлын байрны төлөв (ажлын байраар нөөцөнд бүртгэгдсэн, идэвхитэй ажил хайж буй, тэнцээгүй) -Ажлын байранд шилжсэн -Ярилцлагын үе гат -Дадлагын үе шат Ажлын байрны төлөв (ажлын байранд шилжсэн, ярилцлагийн үе шат, дадлагын үе шат, нөөцөнд бүртгэгдсэн, идэвхитэй ажил хайж буй, тэнцээгүй) Салбар, ангилалаар (банк, теллер гэх мэт)
		Санал зөвлөмж	Платформ туншлэлийн алба нь энэхүү тайланг удирдлагуудад танилцуулж, аль төрлийн ажил олголтыг нэмэх шаардлага үүсэж байгаа зэрэг тайлан мэдээ гаргах, хэрхэн сайжруулах тал дээр ажиллах боломжтой.
3	Сэтгэл ханамжийн	Тайлбар	Санал асуулгын загвар хэрэглэгчийн тохиргоо хийж оруулах /системийн ажилтан оруулах/

	судалгаа оруулах /нээх, хаах/	Талбар	-Дадлага -АБССХ -Бүтэн цагийн -Хагас цагийн -Сайн дурын -Удирдагч багш нараас -Ажил олгогчоос -Ажил горилогчоос Санал асуулгын хугацааг тохируулах -Устгах -Хадгалах -Архивлах
		Санамж	Оролцогч талуудын судалгаагаар цаашид хөгжүүлэх болон сул талууд харагдах сайн талтай.
		Хавсралт	Хавсралтаар оролцогч талуудаас авч болох санал асуулгын маягтыг ажлын төрөл тус бүрээр жишээ болгон орууллаа. Хавсралт8-Хавсралт14 хооронд
4	Тайлан харах, татах	Тайлбар	Тайлан болон сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг дашбоардаар харах.
		Талбар	-Графикт тайлан -Харьцуулсан тайлан -Хугацаагаар хайх, татах, архивлах / pdf, word, excel/ -Эрхээр харах, татах, архивлах / pdf, word, excel/ -Үнэлгээний тайлан холбогдох ажилтнуудад татагдах -Судалгааны нэгтгэлийг харах
		Санал, зөвлөмж	Тайлан мэдээтэй болсноор өөр төрлийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой байгууллагуудад тоо мэдээг гаргаж өгөх, солилцох боломж нэмэгдэнэ. Төгсөгчдийн судалгаанд интерактив, динамик хэлбэрээр тайлан, шинжилгээ хийх боломжтой. Тайлангууд дашбоардаар харах, Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн графикаар харагдах. Excel-ээр татаж авах боломжтой байх.
		Хавсралт	Хавсралт 6.
5	Мэдээлэл оруулах	Тайлбар	1. Ажлын төлөвлөгөө /Оюутан хөгжлийн бодлогын дагуу хийгдэх ажлуудын жилийн төлөвлөгөөг оруулах./ 2. Мэдээ мэдээлэл 3. Сургалтын линк оруулах зэргийг 4. Ажил олгогч бүртгэх Систем хариуцсан ажилтан эсвэл сургалтын алба мэдээллийг оруулах.
		Талбар	1. Жилийн төлөвлөгөө оруулах -Төлөвлөгөө оруулах -Төлөвлөгөө засах -Төлөвлөгөө устгах 2. Ажил олгогч шинээр бүртгэх: -Байгууллагын регистр -Байгууллагын нэр -Үйл ажиллагааны чиглэл -Хаяг -Имэйл -Холбоо барих утас -Гэрээний файл оруулах


			<ul style="list-style-type: none"> -Загвар хадгалах -Устгах -Засвар оруулах -Хадгалах -Мэдээллийг excel рүү хөрвүүлэх <p>3. Сургалтын линк холбох:</p> <ul style="list-style-type: none"> -Сургуулийн нэмэлт сургалтуудын линк холбох, засах, устгах <p>4. Мэдээ мэдээлэл оруулах</p> <ul style="list-style-type: none"> -Гарчиг -Огноо -Сургалтын алба -Текстэн мэдээ
		Санамж	<p>Байгууллагаас анкет ирүүлсэн оюутнаас нэмэлт тодорхойлолт шаардаж болох ба оюутан шаардлагатай тодорхойлолтын хүсэлтийг сургуульд илгээнэ. Ирсэн хүсэлтийн дагуу тодорхойлолтыг файл хэлбэрээр Upload хийх боломжтой байх. -Оюутны ур чадварын тодорхойлолт</p> <ul style="list-style-type: none"> -Оюутны амжилт бүтээлийн тодорхойлолт -Оюутны ёс зүйн тодорхойлолт <p>Оюутны тодорхойлолтуудыг админ ажилтан сургуулийн холбогдох сургалтын албанаас таталт хийж оруулж болно. Сургалтууд нь Moodle талбарт шилжинэ.</p>
		Санал, зөвлөмж	<p>Сургууль дээр явагдаж буй сайн дурын клубуудын мэдээ мэдээллийг оруулах, зар болгон түгээх, клубын үйл ажиллагааг дэмжсэн зарыг нэмэлтээр оруулах бүрэн боломж бүрдэнэ.</p>
6	Календарь оруулах	Тайлбар	<p>Арга хэмжээний календарь буюу оюутан хөгжлийн хөтөлбөртэй холбоотой арга хэмжээнүүд болон холбоотой ажлуудын товлогдсон хугацааг тус календарт сургуулийн зүгээс оруулах.</p>
		Талбар	<p>Компанийн танилцуулах өдөрлөгийг хэрэглэгчийн оруулах тохиргоо хийж оруулах</p> <ul style="list-style-type: none"> -Ажил горилогчоор -Нийт бүр хэрэглэгч -Багш нар -Байгууллага -Мастер -Бакалавар -Төгсөгч <p>Чиглүүлэх уулзалт оруулах хэрэглэгчийн тохиргоог хийж оруулах</p> <ul style="list-style-type: none"> -Ажил горилогчоор -Нийт бүр хэрэглэгч -Багш нар -Байгууллага -Мастер -Бакалавар -Төгсөгч <p>Эвентүүд оруулах - Зохицуулагч оруулахдаа харах хэрэглэгчийн тохиргоо хийж оруулах</p> <ul style="list-style-type: none"> -Ажил горилогчоор -Нийт бүр хэрэглэгч

			<ul style="list-style-type: none"> -Багш нар -Байгууллага -Мастер -Бакалавар -Төгсөгч
7	Админ эрх	Тайлбар	Оролцогч талуудын эрхийн тохиргоог нээх, хаах.
		Талбар	<p>Байгууллагуудын эрхийн тохиргоог нээж өгөх</p> <ul style="list-style-type: none"> -Байгууллага -Овог -Нэр -Албан тушаал -Утас <p>Багш ажилчдын эрхийн тохиргоог хийх</p> <ul style="list-style-type: none"> -Тайлан татах -Бүгдийг харах -Оюутан харах -Байгууллага харах -Сургууль харах -Атгач файл оруулах <p>Нууц үг солих</p> <ul style="list-style-type: none"> - Одоогийн нууц үг оруулах - Шинэ нууц үг оруулах - Давтан оруулах <p>Мэдээллээ шинэчлэх</p> <ul style="list-style-type: none"> - Тэнхим - Ямар албан тушаал - Утасны дугаар - Имэйл хаяг - Овог - Нэр

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Дээрх шаардлагуудын хүрээнд бизнес процессын зураглал дараах байдалтай харагдаж байгааг (Зураг 33)-д харууллаа. Мөн бид дээрх оролцогч 3 тал болох оюутан, сургууль, байгууллагын дэлгэрэнгүй шаардлагын дагуу платформын прототайпыг гаргасан ба Figma систем ашиглан гаргасан прототайпыг (Хавсралт...)-д харуулж байна.

Зураг 33. АБСС-ын процесс зураглал (To Be)



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

ДУГНЭЛТ

1. Дадлага болон АБССХөтөлбөр нь ижил ойлголт бөгөөд оюутан танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа дадлагын хугацаанд практик үйл ажиллагаатай холбоотой бататган гүнзгийрүүлж ур чадваруудыг эзэмших, өөрийн мэргэжлийн салбарт тулгамдсан асуудлуудын талаар тодорхой мэдээлэл олж авах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг ажлын байран дээр эзэмшиж байна. СЭЗИС нь банк, санхүүгийн хөтөлбөрт туршин хэрэгжүүлэхээр АБССХөтөлбөрийг боловсруулсан ба одоогийн ДБСБ-уудын хэрэгжүүлж буй дадлагатай харьцуулахад маш олон үзүүлэлтүүд илүү боловсронгуй болж, сайжирсан байгаа нь харагдсан.
2. Манай улс нь ДБ-ийн системдээ АБССХ-ийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчингүй ба Европын холбооны сайн туршлагыг нэврүүлэхээр 2021-2024 он хүртлэх хугацаанд Европын холбооны “Erasmus+ MONGWBL” төслийг амжилттай хэрэгжүүлээд явж байна. Тус төсөлд 5 орны их сургуулиуд болон Монгол улсын 5 их сургууль, 4 төрийн байгууллага хамтран хэрэгжүүлж байгаа ба төслийн үр дүнд ДБ-ийн сургалтын системд АБССХ-ийн нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төгсөгчдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, ИДС болон ажил олгогч байгууллагын уялдаа холбоо сайжрах орчин бүрдэнэ.
3. АБССХ нь СЭЗИС-ын оюутан хөгжлийн бодлогын хүрээнд бакалавр 2.0 хөтөлбөрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байранд бэлтгэх зорилттой нийцэж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтээр банк, санхүү хөтөлбөрт нийт 20 оюутан, аялал жуулчлалын хөтөлбөрт нийт 15 оюутан амжилттай хамрагдсанаас үзэхэд цаашид оюутнууд болон ажил олгогч байгууллагууд нэмэгдэж улам өргөжих суурь нь тавигдсан.
4. АБССХ-ийн хэрэгжилтэнд ААН, байгууллагууд тогтвортой ажиллах хүчнийг бага зардлаар бэлтгэх давуу талтай. Харин оюутнуудын хувьд цалинтайгаар мэргэжлийнхээ ажлын байранд дадлагажих, хичээлийнхээ кредит цагаа тооцуулах, дадлагажиж буй байгууллагынхаа соёлд суралцаж цаашид жинхэнэ ажилтнаар сонгогдох давуу талууд үүсэж байна.
5. Онол практик хосолсон тус хөтөлбөрөөр дамжуулан оюутнууд ажлын байран дээр шаардагддаг асуудал шийдвэрлэх, хариуцлага хүлээх, цагийн менежмент, баримт бичиг боловсруулах гэх мэт хатуу, зөөлөн ур чадваруудыг тодорхой хэмжээнд эзэмшиж, байгууллагын соёл, дүрэм журам, засаглалын талаар мэдлэг ойлголтыг олж авч байгаа нь сайшаалтай байна. Энэ нь оюутнууд сургуулиа төгсөөд хөдөлмөрийн зах зээл дээр гарахад ажил олгогчийн хүлээлт болон оюутны ур чадварын зөрүүг бууруулж байна.
6. Оролцогч талуудаас авсан судалгаанаас харахад хөтөлбөрт өгч буй үнэлгээ нь сайн байсан хэдий ч цаашид хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулах, хөтөлбөрийн болон бусад ойлгомжгүй тодорхойгүй байдлуудыг бууруулах, мэдээ мэдээллийн хүртээмжтэй байдлыг сайжруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Иймд оролцогч талууд болон, оюутны карьер зуучлалыг холбосон орчин үеийн платформ хөгжүүлэх нь эдгээр асуудлуудыг тодорхой хэмжээнд бууруулахаар харагдаж байна.
7. Олон улсын туршлагаас харахад Манай улсын хувьд АБССХ-ийг амжилттай, хурдтай хэрэгжүүлэхэд ЗГ-ын оролцоо, дэмжлэг нэн тэргүүнд хэрэгтэй байгаа нь харагдаж байна.
8. Сургуулийн карьер үйлчилгээний өнөөгийн байдлыг дэлхийн шилдэг их дээд сургуулиудтай харьцуулахад агуулгын хувьд зөрүү багатай байгаа хэдий ч оюутны хувьд хүртээмжтэй, нэгдсэн байх байдал нь хүргэж байгаа сувгууд, оролцогч талуудаас хамаараад хангалттай байж чадахгүй байгаа нь харагдаж байна. Тиймээс энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор нэгдсэн карьер үйлчилгээний платформ хөгжүүлэх нь зүйтэй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Ажил олгогч:

Хүний нөөцийн хомсдолтой байгаа энэ цаг үед ажил олгогчид их дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, оюутныг төгсөхөөс өмнө өөрийн бизнест зориулан сурган чиглүүлж авах тал дээр дэмжлэгүүдийг үзүүлж ажиллах хэрэгтэй.

Их дээд сургуулиуд:

Оюутны карьер хөгжлийг дэмжих арга хэмжээг нэгдсэн байдлаар олон талаар хөгжүүлэхэд холбогдох талуудыг үр дүнтэй холбож ажиллах хэрэгтэй. Ажил олгогч талтай хамтран ажлын байранд шаардагдах ур чадваруудыг тодорхойлон, хамтран оюутнуудаа сургах хөгжүүлэхийг зорих хэрэгтэй.


Оюутан:

Оюутнууд тухайн хөтөлбөрт хамрагдахын тулд нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагуудын дагуу ур чадваруудаа тодорхой хэмжээнд сайжруулах хэрэгтэй.

Платформ:

- ✓ Томоохон байгууллагууд өөрийн карьер сайтаар дамжуулж анкетаа авч, шинэ ажилтан сонгон шалгаруулалт хийх процессын дагуу авч байгаа тул тухайн байгууллагын карьер платформтай холболт хийгдэх боломжтой байх шаардлага тулгарах магадлалтай.
- ✓ Оюутан тус платформоор дамжуулж оюутан хөгжлийн бодлоготой холбоотой сургалтуудад сууснаараа оноо цуглуулж, цуглуулсан оноо нь Moodle систем болон платформ дээр харагдах боломжтой байх.
- ✓ Процессын төлөв платформ дээр өөрчлөгдсөн тохиолдолд өөрчлөгдөх бүрт оюутны бүртгэлтэй имэйл хаяг болон утасны дугаараар зурвас илгээгдэх боломжтой байх.
- ✓ Оюутны карьер үйлчилгээг тус платформоор дамжуулан хийж байгаа бөгөөд үүнтэй адилаар төгсөгч нарт бүртгэл үүсгэн тус платформоор дамжуулж ажилд зуучлах боломжтой гэж харж байна. Ингэснээрээ сургууль дата мэдээлэл цуглуулахаас гадна тус платформын хэрэглээг илүү үр дүнтэй болгох юм. Оролцогч талд төгсөгчидийг оруулсан тохиолдолд платформын ерөнхий шаардлага дараах байдалтай харагдана.
(Зураг 34)

Зураг 34. Оролцогч талд төгсөгчийг оруулсан платформын шаардлага (Санал, зөвлөмж)



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

НОМ ЗҮЙ

Цахим хуудас:

ELSEVIER. (2023 оны 4 сарын 15). topuniversities.com:
<https://www.topuniversities.com/university-rankings/employability-rankings/2022>-ээс
Гаргасан

Erasmus+MONGWBL. (2023 оны 5 сарын 02). *Төрийн банкны Хүний нөөц, Хууль, Дотоод хяналт шалгалт болон Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн асуудал хариуцсан газар, хэлтсийн удирдлагууд орсон АБСС-ын чиглүүлэх сургалт.* Улаанбаатар:
<https://www.facebook.com/profile.php?id=100064205166468>.

Erasmus+MONGWBL. (2023 оны 3 сарын 10). СЭЗИС-ийн Бакалаврын хөтөлбөрийн шинэчлэл “UFE BACHELOR 2.0”-ийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. *FAM discussion in Banking and Insurance program at Golomt Bank.* Улаанбаатар: <https://www.facebook.com/profile/100064205166468/search/?q=fam>.

ERASMUS+Programme of the Eurpran Union. (2023 оны 4 сарын 2). apprenticeshipq.eu:
<https://apprenticeshipq.eu/a-categorization-of-apprenticeships-and-the-description-of-its-characteristics/>-ээс Гаргасан

INDEED. (2023). *Apprenticeship vs Internship.* Улаанбаатар: <https://www.indeed.com/career-advice/finding-a-job/apprenticeship-vs-internship>.

Massachusetts Institute of Technology. (2023 оны 3 сарын 20). MIT Career Advising&Professional Development: <https://capd.mit.edu/>-ээс Гаргасан

OECD. (2023). *Work-based learning and apprenticeships.* Улаанбаатар:
<https://www.oecd.org/education/skills-beyond-school/work-based-learning-and-apprenticeships.htm>.

Oxford University. (2023 оны 3 сарын 10). Oxford University Careers Service:
<https://www.careers.ox.ac.uk/>-ээс Гаргасан

The University of Sydney. (2023 оны 3 сарын 10). Careers at Sydney:
<https://www.sydney.edu.au/about-us/careers-at-sydney.html>-ээс Гаргасан

The University Of Tokyo. (2023 оны 3 сарын 10). Discover Excellence The University Of Tokyo:
<https://www.u-tokyo.ac.jp/en/about/jobs.html>-ээс Гаргасан

The University Of Tokyo. (2023). *Cereer development.* dfd. <https://www.u-tokyo.ac.jp/en/about/jobs.html>-ээс Гаргасан

Tsinghua University. (2023 оны 4 сарын 30). Careers Tsinghua Edu:
<https://career.tsinghua.edu.cn/careeren/Students.htm>-ээс Гаргасан

- БШУЯ. (2022). *АБСС-ыг дээд боловсролын тогтолцоонд нэвтрүүлнэ*. Улаанбаатар: https://www.meds.gov.mn/post/115971?fbclid=IwAR1bi_RHck_0Fz-V7RSRYXh79e7G6eQUlbb_OKgM42DonMO2nwPlyUdmh2M.
- Голомтбанк. (2022). *Голомт банк АБССХ-ийг ОТИС болон СЭЗИС-тай хамтран хэрэгжүүлж байна*. Улаанбаатар: <https://golomtbank.com/news/28043>.
- Монголын үндэсний телевиз. (2022). *“Ажлын байранд суурилсан сургалт”-ын чиглүүлэх сургалт явагдаж байна*. Улаанаатбар: <https://www.mnb.mn/i/273135>.
- СЭЗИС. (2022). *Бакалаврын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлж байна*. Улаанбаатар: <https://www.ufe.edu.mn/widgetDetail/202>.
- СЭЗИС. (2022). *Оюутны хөгжлийн бодлого | Бакалавр 2.0*. Улаанбаатар: <https://www.youtube.com/watch?v=Dw3Cz0Tt7ks>.
- СЭЗИС. (2022). *СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн АБСС зохион байгуулах журам*. Улаанбаатар: Бакалаврын сургалт, судалгаа хариуцсан проректор.
- СЭЗИС. (2022). *СЭЗИС-ийн Бакалаврын хөтөлбөрийн шинэчлэл “UFE BACHELOR 2.0”-ийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа*. Улаанбаатар: <https://ufe.edu.mn/widgetDetail/179>.
- СЭЗИС. (2023 оны 4 сарын 18). UFE: <https://www.ufe.edu.mn/widgetDetail/669>-ээс Гаргасан
- СЭЗИС. (2023). *Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрт 6 сар хамрагдаж, эхний ээлжийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж дууслаа*. Улаанбаатар: <https://ufe.edu.mn/widgetDetail/715?fbclid=IwAR1w9nZdnlkeXsFdDWhhRzegPidJiGDmZ3hTZ5iimYSpfalTNbi0SG65efY>.
- Төрийн банк. (2023 оны 1 сарын 17). State bank: <https://www.statebank.mn/>-ээс Гаргасан
- ХААИС. (2022). *Дээд боловсролын тогтолцоонд АБССХ-ийг нэвтрүүлнэ*. Улаанбаатар: <https://muls.edu.mn>.
- Судалгааны ажил:*
- Liu Chen, Zhiqun Zhao, Yuqi Chen. (2019). Skill Development of Modern Apprenticeship with Chinese. <https://tvet-online.asia/>.
- Swiss Foundation for Technical Cooperation. (2019). *Apprenticeship Training in Asia*. Myanmar: Swiss Foundation for Technical Cooperation.
- Хүрэлбаатарын ХЭРЛЭН бусад. (2022). *СЭЗИС ба Голомт банкны хамтарсан АБССХ боловсруулах төсөлт ажил*. Улаанбаатар: Мастерын зэрэг горилсон судалгааны ажил.
- Хүрэлбаатарын ХЭРЛЭН бусад. (2022). *СЭЗИС ба Голомт банкны хамтарсан АБССХ боловсруулах төсөлт ажил*. Улаанбаатар.

Хүрэлбаатарын ХЭРЛЭН бусад. (2022). *СЭЗИС ба Голомт банкны хамтарсан АБССХ боловсруулах төсөлт ажил*. Улаанбаатар: Товч хураагуй.

Хүрэлбаатарын ХЭРЛЭН бусад. (2023 оны 2 сарын 28). *СЭЗИС ба Голомт банкны хамтарсан АБССХ боловсруулах төсөлт ажил. Мастерын зэрэг горилсон судалгааны ажил*, хуудсд. 60-81.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Дадлагажигч оюутнуудаас авсан судалгааны асуулгын маягт

Дадлагачигч оюутнуудаас авах судалгааны асуулгын маягт

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэхүү судалгааны зорилго нь АБССХ(Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр)-ийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлоход оршино.

I. Хөтөлбөртэй холбоотой асуулгууд:

1. Та хөтөлбөрийн хэддүгээр ээлжинд хамрагдсан бэ?
 - a. 1-р ээлж 2022/10/03-2023/03/31
 - b. 2-р ээлж 2023/01/01-2023/06/30
2. Дадлагын аль үе шатанд дадлагажиж байна вэ?
 - a. 1-р үе шат
 - b. 2-р үе шат
3. Та аль банкинд дадлагажиж байна вэ?
 - a. Голомт банк
 - b. Төрийн банк
4. Та ямар албан тушаалд дадлагажиж байна вэ? /Бичнэ үү./
5. Та өөрийн хүссэн албан тушаалдаа ажиллаж чадсан уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
6. Үгүй бол дадлагажихыг хүсэж буй албан тушаалаа бичнэ үү?
7. Яагаад энэ албан тушаалд дадлагажихыг хүсэж байна вэ? /Бичнэ үү./
8. Шаардлагатай ур чадварыг ажлын байран дээрээс эзэмшиж чадсан уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
9. Ажлын байран дээрээс эзэмшсэн Soft skills.
 - a. Багаар ажиллах
 - b. Асуудлыг шийдвэрлэх
 - c. Цагийн менежмент
 - d. Харилцаа холбоо тогтоох
 - e. Хариуцлагаа ухамсарлах
 - f. Манлайлах
 - g. Уян хатан байдал стрессээ удирдах
 - h. Бусад
10. Ажлын байран дээрээс эзэмшсэн Hard skills.
 - a. Баримт бичиг боловсруулах
 - b. Оффисын програмууд дээр ажиллах
 - c. Банкны програм дээр ажиллах
 - d. Бүтээлч байдал, шинийг санаачлагч

- e. Идэвхитэй бие дааж сурах
- f. Аналитик сэтгэлээ, инноваци
- g. Бусад

11. Дараах зүйлсийг 1-5 оноогоор үнэлнэ үү. /1 Маш муу, 2 Муу, 3 Дундаж, 4 Сайн, 5 Маш сайн/

	1	2	3	4	5
Байгууллагын соёл					
Оролцогч талуудын уялдаа холбоо					
Дадлагын ажил нь тайлангийн сэдэвтэйгээ уялдсан байдал					
Дадлагын тайлангийн үнэлгээ					
АБССХ-ийг үнэлэх					

12. Хөтөлбөрөөс ойлгомжгүй, тодорхойгүй зүлс байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй

13. Тийм бол бичнэ үү.

14. Хөтөлбөрийг сайжруулахтай холбоотой арга замын талаар бичнэ үү.

15. Хөтөлбөрийн бусад оролцогч талуудтай ямар төрлийн харилцаа холбоогоор холбогдож байсан бэ?

- a. Утсан харилцаа
- b. Facebook messenger
- c. Viber
- d. Мессеж
- e. Имэйл
- f. Бусад

16. Оролцогч талуудтай харилцах нэгдсэн платформ шаардлагатай эсэх.

- a. Тийм
- b. Үгүй

17. Тайлан хамгаалалтын үнэлгээ ил тод, ойлгомжтой байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй

18. Үгүй бол бичнэ үү.

19. Ментор буюу дадлагажсан хэлтэс/нэгжийн удирдах албан тушаалтан таныг мэдээллээр хэр хангаж байсан бэ?

- a. Байнга тусалж дэмжиж, даалгавар өгч буцааж шалгаж байсан.
- b. Завтай үедээ
- c. Асуусан тохиолдолд хариулдаг.
- d. Тусалж дэмжээгүй
- e. Бусад

20. Дадлага хийнгээ хичээлээ судлах нь ачаалалтай байсан уу?

- a. Тийм
- b. Үгүй

21. Хөтөлбөрийн талаарх мэдээллийг анх хаанаас авсан бэ?

- a. Сургалтын алба

- b. Сургуулийн FB page
 - c. Сургуулийн цахим хуудас
 - d. Найз нөхөд
 - e. Танил
 - f. Бусад
22. Тус хөтөлбөрийг сонгосон шалтгаан?
- a. Цалинтай
 - b. Ажлын байран дээрээс шаардлагатай ур чадвар эзэмших
 - c. Төгсөөд ажлын байраар хангагдах боломжтой
 - d. Ажиллангаа хичээлээ дүйцүүлэх боломжтой
 - e. Олон улсад туршигдсан хөтөлбөр
 - f. Ментортой тул сурах зүйлээ асуугаад их юм сурах
 - g. Хэрэглээний мөнгөө өөрөө олно
 - h. Бусад
23. Дүйцүүлэх хичээлийн сонголт хэр оновчтой санагдсан бэ?
- a. Оновчтой
 - b. Оновчгүй
24. Хөтөлбөрийн хугацаа хэр тохиромжтой байсан бэ?
- a. Богино
 - b. Дунд
 - c. Урт
 - d. Бусад

25. Хөтөлбөрийн талаарх таны сэтгэгдэл?

	Маш өндөр	Өндөр	Дундаж	Муу	Маш муу
Хөтөлбөрийн өмнөх үе					
Хөтөлбөрийн дараах үе					

26. Дадлагажиж буй байгууллагадаа хэр сэтгэл ханамжтай байна вэ?

	Маш өндөр	Өндөр	Дундаж	Муу	Маш муу
Сэтгэл ханамж					

27. Хөтөлбөрийн давуу тал нь юу байсан бэ? /Бичнэ үү./
28. Хөтөлбөрийн сул тал нь юу байсан бэ? /Бичнэ үү./
29. Дадлагажсан байгууллагаас таньд ажлын санал ирвэл та хүлээж авах уу?
- a. Тийм
 - b. Үгүй
30. Тийм бол яагаад?
- a. Байгууллагын соёл таалагдсан
 - b. Хамт олны уур амьсгал таалагдсан
 - c. Тус албан тушаалын хийж буй ажил нь таалагдсан
 - d. Сурч хөгжих боломжтой
 - e. Өсөн дэвших боломжтой
 - f. Бусад
31. Үгүй бол яагаад?
- a. Байгууллагын соёл
 - b. Цалин бага

- c. Сурч хөгжих боломж бага
- d. Өсөн дэвших боломжгүй
- e. Бусад

II. Хувийн асуулгын хэсэг

1. Таны хүйс
 - a. Эрэгтэй
 - b. Эмэгтэй
2. Та хэддүгээр курсын оюутан бэ?
 - a. 3-р курс
 - b. 4-р курс
3. Таны сард авч байсан цалингийн хэмжээ?
 - a. 420,000-550,000
 - b. 550,001-650,000
 - c. 650,001-750,000
 - d. 750,001-850,000
 - e. 850,001 төгрөгнөөс дээш
4. Та өөрийн авч буй цалинд сэтгэл хангалуун байна уу?
 - a. Гийм
 - b. Үгүй
5. Үгүй бол хэд байвал тохиромжтой гэж үзэж байна вэ? /Бичнэ үү./

Хавсралт 2. Удирдагч багшаас авсан судалгааны асуулгын маягт

Удирдагч багшаас авах судалгааны асуулгын маягт

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэхүү судалгааны зорилго нь АБССХ(Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр)-ийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлоход оршино.

1. Та удирдагч багш болохоос өмнө АБССХ-ийн талаар хэр мэдээлэлтэй байсан бэ?
 - a. Маш сайн
 - b. Сайн
 - c. Дунд
 - d. Муу
2. Одоо сургуулийн зүгээс хөтөлбөртэй холбоотой мэдээ мэдээллээр хэр хангаж байна вэ?
 - a. Сайн
 - b. Дунд
 - c. Муу
3. Дадлагын ментертой харилцахдаа харилцаа холбооны ямар сувгуудийг ашиглаж байна вэ?
 - a. Мессэж
 - b. Фэйсбүүк мессенжэр
 - c. Утсан харилцаа

- d. Имэйл
 - e. Бусад
4. Удирдаж буй оюутныхаа ментортой харилцахад асуудал үүсэж байна уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
 5. Тийм бол үүсэж буй асуудлуудыг бичнэ үү.
 6. Оюутнуудтай харилцахдаа харилцаа холбооны ямар сувгуудыг ашиглаж байна вэ?
 - a. Имэйл
 - b. Биечилсэн уулзалт
 - c. Утсан харилцаа
 - d. Бусад онлайн цахим хэрэгсэл
 - e. Бусад
 7. Хөтөлбөр эхэлснээс хойш оролцогч талуудтай хэдэн удаа холбогдсон бэ?

Оролцогч	1-3	4-6	7-9	10 буюу түүнээс дээш	Огт холбогдоогүй
Ментор					
Оюутан					

8. Хөтөлбөрт удирдагч багшаар ажилласнаар таны ачаалал хэр нэмэгдсэн бэ?
 - a. Маш их
 - b. Их
 - c. Дунд
 - d. Бага
 - e. Маш бага
9. Хөтөлбөр хэрэгжиж байгаа хугацааг тохиромжтой гэж үзэж байна уу?
 - a. Их
 - b. Бага
 - c. Тохиромжтой
10. Үгүй бол тохиромжтой хугацааг бичнэ үү.
11. Таны бодлоор хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
12. Үгүй бол шалтгааныг бичнэ үү.
13. Танилцах болон мэргэжлийн дадлагатай харьцуулахад АБССХ-ийн оюутанд бий болгож буй давуу талыг үнэлнэ үү. /5 Их, 4 Дунд, 3 Бага/

	3	4	5
Хэрэгцээ шаардлага			
Хэрэгжилтийн үр дүн			
Оролцогч талуудын уялдаа холбоо			
Оюутны ахиц дэвшил			

14. АБССХ хэрэгжсэнээр хөтөлбөрийн өрсөлдөх чадвар, шинэ оюутан татах элсэлтэнд давуу талыг бий болгож чадах уу?
 - a. Тийм

б. Үгүй

15. Хөтөлбөрийн давуу тал нь юу вэ? /Бичнэ үү./

16. Хөтөлбөрийн сул тал нь юу вэ? /Бичнэ үү./

17. Хөтөлбөр цаашид хэрэгжих ёстой гэдэгтэй санал нийлж байна уу?

а. Тийм

б. Үгүй

18. Үгүй бол яагаад?

19. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цаашид юун дээр анхаарах вэ? Сайжруулах санал байвал бичнэ үү.

Хавсралт 3. Сургуулийн зохицуулагчаас авсан судалгааны асуулга.

Сургуулийн зохицуулагчаас авсан судалгааны асуулга

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэхүү судалгааны зорилго нь АБССХ(Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр)-ийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлоход оршино.

Ярилцлагын асуултууд:

1. Зохицуулагчаар ажиллахаас өмнө та АБССХ-ийн талаар хэр мэдээлэлтэй байсан бэ?
2. Хөтөлбөрийн баримт бичиг, төлөвлөгөө хэр ойлгомжтой байсан бэ?
3. Бусад оролцогч талуудтай харилцааны ямар сувгаар хамтран ажиллаж байсан бэ?
4. Бусад талуудтай харилцаж байгаа тайлангаа ямар төрлийн файл дээр нэгтгэж байсан бэ?
5. Таны бодлоор сургуулийн зүгээс оролцогч талуудыг холбосон нэгдсэн платформ байх шаардлагатай юу?
6. Оюутнуудын зүгээс танд санал гомдол гаргаж байсан уу? Тийм бол та дэлгэрэнгүй бичнэ үү. Хэрхэн хүлээн авч шийдвэрлэсэн бэ?
7. Хөтөлбөртэй холбоотой үүсэж буй асуудлууд юу байна вэ?
8. Байгууллагын зохицуулагч талуудаас ямар санал гомдол ирж байсан бэ? Хэрхэн хүлээн авч шийдвэрлэсэн бэ?
9. 2 ээлжийн хөтөлбөрт та хэрхэн үнэлгээ өгөх вэ?
10. Сургуулийн удирдлагын зүгээс цаашид хөтөлбөрийг дэмжиж оролцоход юу санаачлах шаардлагатай вэ?
11. Хөтөлбөрт ажиллах нь таны үндсэн ажилд хэр их ачаалал нэмж байна бэ?
12. Нэмэгдэл цалин, урамшуулал авч байсан уу?
13. Хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд анхаарах зүйлс юу байна вэ?
14. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа тохиромжтой байна уу?
15. Оюутнуудтай та хэдэн удаа уулзалт хийсэн бэ?
16. Хөтөлбөрийн давуу тал нь юу вэ?
17. Хөтөлбөрийн сул тал нь юу вэ?

Ажил олгогч талаас зарын мэдээлэл оруулах болон заримт сургуульд бүртгэлгүй байгууллагын зарыг оруулах тохиолдолд ажлын байрны төрлүүдээс хамааран оруулах мэдээллүүд өөр байна. Дараах хүснэгтэнд ажлын байрны төрөл тус бүрээр оруулах

мэдээллүүдийн талбаруудыг харууллаа. Тус талбаруудад ямар мэдээлэл харагдахыг жишээ болгон (Хавсралт 5)-д оруулсан.

Хавсралт 4. Ажлын байрны төрөл тус бүрээр мэдээлэл харагдах байдал

№	Ажлын байрны төрөл	Дадлага	Сайн дурын ажил	АБССХ	Бүтэн цагийн ажил	Хагас цагийн ажил
1	Ажлын байрны нэр	+	+	+	+	+
2	Байгууллагын нэр	+	+	+	+	+
3	Гүйцэтгэх ажил, үүрэг	+	+	+	+	+
4	Ажлын байранд тавигдах шаардлага мэргэжлийн ур чадвар	+		+	+	+
5	Ажлын байранд тавигдах шаардлага ерөнхий ур чадвар		+		+	+
6	Ажлын байранд тавигдах шаардлага тусгай ур чадвар				+	
7	Цагийн хуваарь	+	+	+	+	+
8	Хугацаа	+	+			+
9	Цалин				+	+
10	Сул орон тоо	+	+	+	+	+
11	Сул орон тоо нөхөх сүүлийн огноо	+	+	+	+	+

Хавсралт 5. Ажлын байрны зар ажлын байрны төрлүүдээр харах

Ажлын байрны нэр	Дадлагын оюутан	Сайн дурын ажилтан	Теллер	Нягтлан бодогч	Чиглүүлэгч ажилтан
Байгууллагын нэр	Юнител ХХК	ТББ	М банк	Юнител ХХК	Юнител ХХК
Гүйцэтгэх ажил, үүрэг	Нягтлан бодох бүртгэлийн нэгжийн ажилд дэмжлэг үзүүлэх, бичиг баримт архивлах	Хандивын аяны арга хэмжээнд чиглүүлэгч ажилтан хийх	АБССХ-ийн дагуу	Компанийн бүртгэл хөтлөлтийг анхан шатны баримтанд үндэслэн СТОУС, татварын хууль тогтоомжид үндэслэн хөтлөн явуулах	ICT expo арга хэмжээний өдрүүдэд сонирхогчдод брошур тараах, мэдээлэл хүргэх ажил хийх
Ажлын байранд тавигдах шаардлага мэргэжлийн ур чадвар	Нягтлан бодогч мэргэжлийн 3, 4-р курсын оюутан Дүнгийн голч 3.0 болон түүнээс дээш Дадлагын удирдамж		Банкны мэргэжлийн 3-р курсын оюутан	Нягтлан бодогч мэргэжлээр их дээд сургууль төгссөн Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын мэдлэгтэй Татварын хуулийн мэдлэгтэй	
Ажлын байранд тавигдах шаардлага ерөнхий ур чадвар		Насанд хүрсэн байх		Хариуцлагатай нямбай Хувийн зохион байгуулалт сайтай Бие даан суралцах чадвартай	Насанд хүрсэн байх Ярианы ур чадвартай

Ажлын байранд тавигдах шаардлага тусгай ур чадвар				Сард нэг удаа орон нутаг руу томилолтоор явж ажиллах боломжтой байх	Англи хэлний ярианы чадвартай бол давуу тал болно
Ажлын байрны төрөл	Дадлага	Сайн дурын ажил	АБССХөтөлбөр	Бүтэн цагийн ажил	Хагас цагийн ажил
Цагийн хуваарь	10:00-17:00	11:00-16:00	09:00-18:00	09:00-18:00	11:00-18:00
Хугацаа	1 сар	1 өдөр	6 сар		3 өдөр
Цалин		Өдрийн хоолтой	Цалин ххх	Цалин ххх	Цагийн хөлс - ххх
Сул орон тоо	1	5	2	2	5
Сул орон тоо нөхөх сүүлийн огноо	5/15/2023	5/15/2023	5/15/2023	5/15/2023	5/15/2023

Хавсралт 6. Тайлангийн үзүүлэлтүүд

Нас	Хүйс	Мэргэжил	MCS	Тэнцсэн	Ажилд авах	Дадлага	Шинээр бүртгэгдсэн	Бакалавр	Цалингийн хэмжээ /төгрөг/	Тайлангийн татах хугацаа
21-с доош	Эр	Нягтлан бодогч	Unitel	Нөөцөнд бүртгэгдсэн	Татгалзах	Сайн дурын	Бүртгэл усгасан	Мастер	500,000 хүртэл	Сүүлийн 1 өдөрт нэмэгдсэн
21-22	Эм	Теллер	Mobicom	Тэнцээгүй	Нөөцөнд бүртгэх	АБССХ		1-р курс	500,000-600,000	Сүүлийн 7 хоногт нэмэгдсэн
22-23		Санхүүгийн шинжээч		Ярилцлага		Бүтэн цагийн ажил		2-р курс	600,000-700,000	Сүүлийн 1 сард нэмэгдсэн
23-с дээш						Хагас цагийн ажил		1-р курс	700,000-800,000	Сүүлийн 1 жилд нэмэгдсэн
								2-р курс	800,000-900,000	
								Төгсөгч	1,000,000-с дээш	

Хавсралт 7. Ажил олгогчийн эрх, үүрэг

Ажил олгогч нь өөрийн эрх, үүргийг уншиж танилцсанаар ажлын байрны зарыг оруулах боломжтой болох ба АБССХ-ийн хувьд ажил олгогчийн эрх үүргийг жишээ болгон орууллаа.

1. Ажил олгогчийн эрх

1.1 ААНБ-тай байгуулсан гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлээгүй зөрчсөн, цаашид үргэлжлүүлэн гэрээний дагуу ажиллуулах боломжгүй суралцагчийг хөтөлбөрт хамруулахаас татгалзах, өөрийн байгууллагад цаашид ажиллуулахаас татгалзах эрхтэй.

1.2 Оюутан АБСС-д хамрагдах хугацаандаа зөрчил гаргасан тохиолдолд Талуудын дотоодод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлого, дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэх ба шаардлагатай гэж үзвэл, тухайн оюутныг хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулахгүй байж болно. Арга хэмжээ авхуулсан оюутны үнэлгээг гаргаж өгөхөөс татгалзах эрхтэй.

2. Ажил олгогчийн үүрэг

2.1 АБСС эхлэхээс өмнө хөтөлбөрт хамрагдаж буй суралцагчийн ажил гүйцэтгэх ажлын байр, ажлын байрны тодорхойлолт, хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган ДБСБ-д албан ёсоор танилцуулах үүрэгтэй.

2.2 АБСС-ыг боловсруулсан удирдамж, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх, оюутныг үйл ажиллагаатай танилцуулах, ажлын байрны шаардлагад тавигдах мэдлэг, ур чадварт суралцуулах, ажил олгогч байгууллагын шаардлагад нийцсэн чадварлаг мэргэжилтэн бэлтгэх чиглэлд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

2.3 АБСС-ыг үр дүнтэй явуулах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, хөтөлбөрт хамрагдаж буй оюутныг удирдан чиглүүлэх, ажлын байранд дадлагажуулах, зааж сургах үүрэг бүхий чиглүүлэгчийг томилон ажиллуулах үүрэгтэй.

2.4 Чиглүүлэгч нь АБСС-ын хөтөлбөрийн дагуу оюутанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх боломж, бололцоог зохицуулагч болон салбар, нэгжийн ажилтнуудад олгох үүрэгтэй.

2.5 Хөтөлбөрийн зохицуулагч нь АБСС-ыг хөтөлбөрийн дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавьж, оюутны гүйцэтгэсэн ажил, хүрсэн үр дүн, сахилга хариуцлагын үнэлгээг хийж, эцсийн үнэлгээ болон АБСС-ын мэдээ, тайланг гаргаж ДБСБ-д хүргүүлэх үүрэгтэй.

2.6 ААНБ нь оюутанд 1.2-д заасан арга хэмжээг авсан тохиолдолд ДБСБ-д мэдэгдэх үүрэгтэй.

Сургууль нь оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгааг авах ба тухайн судалгааны асуулгуудыг тодорхой хугацаанд нээх болон хаах эрхтэй байна. Энэ нь оюутан талаасаа мөн байгууллага талаасаа өгөх судалгааны асуулга нь ялгаатай байхаар дараах асуулгуудыг жишээ болгон орууллаа. Энэхүү судалгааны зорилго нь оюутны хөгжлийн хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлоход оршино.

Хавсралт 8. Бүтэн цагийн ажилд зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулга

32. Та ямар албан тушаалын ажилд тэнцсэн бэ?
33. Та хүссэн албан тушаалдаа ажилд орж чадсан уу?
 - a) Тийм
 - b) Үгүй
34. Та ажилд орох хүртэл ямар хугацаа зарцуулсан бэ?
 - a) 1 сар хүртэл
 - b) 2-6 сар хүртэл
 - c) 7-12 сар хүртэл
 - d) 12-ээс дээш
35. Таньд ажил олгогч талуудтай харилцахад энэхүү платформ ойлгомжтой байсан уу?
 - a) Ойлгомжтой
 - b) Ойлгомжгүй
36. Ойлгомжгүй зүйл байсан бол тайлбарлана уу?
37. Таньд ажилд ороход сургуулийн зүгээс ямар төрлийн сургалт хэрэгтэй байна вэ?
38. Танийг ажилд тэнцэхэд дараах ур чадвараас аль нь илүү давуу байдал үүсгэсэн бэ?

	Маш их	Их	Дунд	Бага	Маш бага
Сурлагын дүн					
Хэлний мэдлэг					
Харилцааны ур чадвар					
Багаар ажиллах ур чадвар					
Хурдтай суралцах чадвар					

Хавсралт 9. Дадлагад зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулгын загвар

1. Та ямар албан тушаалд дадлагажсан бэ?
2. Та дадлагад орох хүртэл ямар хугацаа зарцуулсан бэ?
 - e) 1 сар хүртэл
 - f) 2-3 сар хүртэл
 - g) 4-5 сар хүртэл
 - h) 5-ээс дээш
3. Таньд ажил олгогч талуудтай харилцахад энэхүү платформ ойлгомжтой байсан уу?
 - c) Ойлгомжтой
 - d) Ойлгомжгүй
4. Ойлгомжгүй зүйл байсан бол бичнэ үү?
5. Та хэдэн сар дадлагажсан бэ?
 - a) 1 сар
 - b) 2 сар
 - c) 3 сар

- d) 3-с дээш сар
6. Дадлага хийж байхад ямар хүндрэлтэй асуудлууд гарч байсан бэ?
 7. Таны дадлагын ажил цалинтай байсан уу?
 - a) Тийм
 - b) Үгүй
 8. Дадлагажих хугацаандаа дараах ур чадвараас сурч чадсан уу?

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
Сурлагын дүн					
Хэлний мэдлэг					
Харилцааны ур чадвар					
Багаар ажиллах ур чадвар					
Хурдтай суралцах чадвар					

Хавсралт 10. Хагас цагийн ажилд зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулгын загвар

1. Та ямар ажлын байранд тэнцсэн бэ?
2. Та хүссэн албан тушаалдаа ажилд орж чадсан уу?
 - a) Тийм
 - b) Үгүй
3. Та хагас цагийн ажилд орох хүртэл ямар хугацаа зарцуулсан бэ?
 - a) 1 сар хүртэл
 - b) 2-6 сар хүртэл
 - c) 7-12 сар хүртэл
 - d) 12-ээс дээш
4. Таньд ажил олгогч талуудтай харилцахад энэхүү платформ ойлгомжтой байсан уу?
 - a) Ойлгомжтой
 - b) Ойлгомжгүй
5. Ойлгомжгүй зүйл байсан бол тайлбарлана уу?
6. Цагийн ажлын хөлс нь хэд байсан бэ?
7. Танийг ажилд тэнцэхэд дараах ур чадвараас аль нь илүү давуу байдал олгосон бэ?

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
Сурлагын дүн					
Хэлний мэдлэг					
Харилцааны ур чадвар					
Багаар ажиллах ур чадвар					
Хурдтай суралцах чадвар					

Хавсралт 11. Сайн дурын ажилд зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны загвар

1. Таньд ажил олгогч талуудтай харилцахад энэхүү платформ ойлгомжтой байсан уу?

- a) Ойлгомжтой
 - b) Ойлгомжгүй
2. Ойлгомжгүй зүйл байсан бол тайлбарлана уу?
 3. Таны сонгож оролцсон ажлын сайн тал нь юу вэ?
 4. Сул тал нь юу вэ?
 5. Та дахиж сайн дурын ажилд оролцох уу?
 - a) Тийм
 - b) Үгүй
 6. Та найз нөхөддөө энэхүү ажлын талаар санал болгох уу?
 - a) Тийм
 - b) Үгүй

Хавсралт 12. АБССХ-т зуучлагдсан оюутнуудаас авах судалгааны асуулгын загвар

1. Та ямар албан тушаалд дадлагажсан бэ?
2. Та хүссэн албан тушаалдаа ажилд орж чадсан уу?
 - a) Тийм
 - b) Үгүй
3. Та энэ хөтөлбөрт хамрагдах хүртэл ямар хугацаа зарцуулсан бэ?
 - a) 1 сар хүртэл
 - b) 2-6 сар хүртэл
 - c) 7-12 сар хүртэл
 - d) 12-ээс дээш
4. Танд ажил олгогч талуудтай харилцахад энэхүү платформ ойлгомжтой байсан уу?
 - a) Ойлгомжтой
 - b) Ойлгомжгүй
5. Ойлгомжгүй зүйл байсан бол тайлбарлана уу?
6. Энэ хөтөлбөрт оролцоход сургуулийн зүгээс ямар төрлийн сургалт хэрэгтэй байна вэ?
7. Хөтөлбөрт хамрагдсанаар дараах ур чадвараас олж авсан мэдлэгээ үнэлнэ үү?

	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу
Сурлагын дүн					
Хэлний мэдлэг					
Харилцааны ур чадвар					
Багаар ажиллах ур чадвар					
Хурдтай суралцах чадвар					

8. Хөтөлбөрийн давуу тал юу вэ?
9. Хөтөлбөрийн сул тал юу вэ?

Хавсралт 13. АБССХ-т оролцсон байгууллагаас авах судалгааны асуулгын загвар

Энэхүү судалгааны зорилго нь оюутны хөгжлийн хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлоход оршино.

1. Энэ хүү хөтөлбөрийн талаар та мэдээлэлтэй байсан уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
1. Танай байгууллага цаашид жил бүр энэхүү хөтөлбөрт оролцох уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
2. Үгүй бол яагаад
3. Хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын дадлагын хугацаа ямар байсан бэ?
 - a. Урт
 - b. Богино
 - c. Боломжийн
4. Таньд энэхүү платформ ойлгомжтой байсан уу?
 - a. Ойлгомжтой
 - b. Ойлгомжгүй
5. Ойлгомжгүй зүйл байсан бол тайлбарлана уу?
6. Манай оюутнуудад ямар давуу талууд байсан бэ?
7. Манай оюутнуудтай ажиллахад ямар яамр сул талууд байсан бэ?

Хавсралт 14. СЭЗИС-ийн оюутнуудад ажил олгогч байгууллагаас авах судалгааны асуулга

Энэхүү судалгааны зорилго нь оюутны хөгжлийн хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамж, хэрэгжилтийн үр дүнтэй байдал, тулгамдаж буй асуудлууд, хүндрэл бэрхшээлийг тодорхойлоход оршино.

1. Танай байгууллага цаашид манай сургуультай хамтарч ажиллах уу?
 - a. Тийм
 - b. Үгүй
2. Үгүй бол яагаад
3. Таньд энэхүү платформ ойлгомжтой байсан уу?
 - a. Ойлгомжтой
 - b. Ойлгомжгүй
4. Ойлгомжгүй зүйл байсан бол тайлбарлана уу?
5. Манай оюутнуудад ямар давуу талууд байсан бэ?
6. Манай оюутнуудтай ажиллахад ямар яамр сул талууд байсан бэ?

Хавсралт 15. Платформын прототайп